



М

ОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • III • № 29



**Н.БАЯРТСАЙХАН:
ЭДИЙН ЗАСАГТ
ГАРСАН НААШТАЙ
ҮР ДҮНГ УЛАМ
БАТЖУУЛЖ,
ТОГТВОРЖУУЛАХЫГ
ДЭМЖИНЭ**

**БАНК ЯАГААД
ХАРИЛЦАГЧАА БҮРЭН
ТАНЬЖ МЭДЭХ
ШААРДЛАГАТАЙ
БАЙДАГ ВЭ?**

Зургийн тайлбар: Худалдаа аж үйлдвэрийн банкны
Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хот дахь 1-р салбар

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Бодлогын хүүг хэвээр хадгалах, тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг шинэчлэх тухай

Дугаар: 2019/01

Огноо: 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах, Банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 60 хувиар шинэчлэн тогтоох шийдвэр гаргалаа.

Жилийн инфляци 2019 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 6.9 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 7.9 хувьтай байна. Инфляцийн хэлбэлзэл нь шатахуун, мах болон хатуу түлшний үнийн өөрчлөлтөөр голлон тодорхойлогдож байгаа бол эрэлтийн шалтгаантай суурь инфляци харьцангуй тогтвортой байна.

Энэ онд эдийн засгийн идэвхжил үргэлжилж, инфляци зорилтод түвшний орчимд тогтворжих хандлага хэвээр байна. Мөнгөний бодлогын хороо инфляцид нөлөөлж буй эрэлт, нийлүүлэлтийн болон гадаад хүчин зүйлс, тэдгээрийн цаашдын төлөв, бизнесийн идэвхжилийг харгалзан бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалахаар шийдвэрлэлээ. Цаашид дотоод эрэлт үргэлжлэн хүчтэй тэлэх тохиолдолд мөнгөний бодлогын хүүг өсгөх шаардлага үүсч болзошгүй.

Тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг бууруулж, 60 хувиар тогтоох шийдвэр нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсч, өндөр түвшинд хүрсэн хэрэглээний зээл, иргэдийн өрийн дарамтыг цалингийн өсөлттэй уялдуулан аажмаар бууруулах зорилготой юм.

Мөнгөний бодлогын хорооны энэ удаагийн шийдвэр нь инфляцийг зорилтот түвшний орчимд тогтворжуулах, макро эдийн засгийн болон санхүүгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалах зорилттой нийцэж байгаа болно.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Арилжааны банкуудын ТУЗ-ийн хараат бус гишүүдтэй санал солилцох уулзалт хийв

5

Ярилцлага:

ХУУДАС

Д.Ган-Очир: Хэрэглээний зээлийн өсөлт зохистой түвшинд хүрснээр санхүүгийн эрсдэлийг бууруулна

7

Байр суурь:

ХУУДАС

Хэрэглээний зээлийг яагаад хязгаарлах шаардлагатай вэ?

10

Индэр:

ХУУДАС

“Тинкбанк 2019-мөнгө, санхүүгийн орчин” хэлэлцүүлгийг нээж Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы хэлсэн үг

13

Мөнгөн**тэмдэгтийн түүх:**

ХУУДАС

Бэрх хааны мөнгөн зоос 1257 - 1267 он

15

Нийтлэл:

ХУУДАС

Дотоодын үйлдвэрлэлийг сэргээж, мөнгө санхүүгийн орчныг тогтворжуулна

16

Ярилцлага:

ХУУДАС

Төв банк удаан хугацаанд алдагдалтай ажиллах нь үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэлтэй

22

Асуулт, хариулт

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас (2019.02.27)

28

Банкир:

ХУУДАС

Жероме Пауэл ба Холбооны Нөөцийн банкны хараат бус байдал

32

Дэлхийн үйл явдал:

ХУУДАС

Давос 2019 юу хэлэлцэв?

36

Судалгаа:

ХУУДАС

Геополитикийн зарим асуудалд төв банкуудын бодлогын хүүний нөлөөлөл

38

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Санхүүгийн луйвраас болгоомжил: Үнэгүй бяслаг хавханд л бий

41

“Ам.долларын шилжүүлэг ба олон улсын байгууллагуудын шаардлага” сэдэвт хэлэлцүүлэг боллоо

2019.03.01

Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба болон Монголын банкны холбоо хамтран энэхүү хэлэлцүүлгийг банкны харилцагчдад зориулан зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр хөндсөн гол асуудал бол мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотойгоор банкнаас харилцагчийг таньж мэдэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах асуудлуудын талаар байлаа. Гадаад төлбөр тооцоонд нэмэлт асуулга, тодруулга авах зэрэг хүндрэлүүд ихээхэн гарах болсон тул банкны зүгээс шаардсан баримт бичгийг тухай бүр гаргаж өгөх нь төлбөр тооцоог цаг алдалгүй хийхэд дөхөмтэй аж. Тиймээс гадаад төлбөр тооцоонд учирч байгаа хүндрэл, тавигдаж байгаа шаардлага, төлбөр тооцоог саадгүй, түргэн шуурхай явуулахад анхаарах шаардлагатай зүйлсийн талаар заавар, зөвлөгөө өгсөн юм. Цаашид Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үнэлгээг ахиулах чиглэлээр УИХ, Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг олон нийтэд таниулах шат дараатай арга хэмжээг авах нь зүйтэй болохыг хэлэлцүүлэгт үзсэн юм.



“Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага -2019” ээлжит хуралд Монголбанкнаас илтгэл тавьж оролцов

2019.03.12



Хуралд эдийн засаг, санхүүгийн салбарын бодлого боловсруулагч, судлаач, хэвлэл мэдээллийн ажилтнууд, оюутнууд болон хувийн хэвшлийн төлөөлөл оролцож, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд тулгамдаж буй асуудлууд тэдгээрийг шийдвэрлэх арга замуудын талаар байр сууриа илэрхийллээ. Энэ үеэр судлаачид эдийн засгийн төлөв байдлыг дүгнэхдээ эмзэг хэвээр байхыг онцлоод, урт хугацаанд гадны хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр нөхцөл байдлыг сайжруулахаас өөр аргагүй байгааг хэлсэн юм. Манай улсын хувьд уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн бүтэц нь удаан оршин тогтнох боломжгүй тул хөдөө, аж ахуй, аялал жуулчлал зэрэг бусад салбаруудаа хөгжүүлэх, үүнд хэрхэн яаж гадны хөрөнгө оруулалтыг татах бодлого чухал байгааг хэлэлцэж, хөрөнгө оруулалт хангалтгүй байгаагийн гол шалтгаан нь эрсдэлтэй улс оронд тооцогдох болсонтой холбоотой тул хөрөнгө оруулагчдыг дэмжсэн төрийн бодлого нэн шаардлагатайг тэмдэглэж байв.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал болов

2019.03.21

Ээлжит хурлаар Монголбанкны 2018 оны төсөв, түүний ашиглалт, төсвийн удирдлагын талаарх мэдээллийг сонсч, Монголбанк төсөвт зардал, түүний хуваарилтыг өөрийн үндсэн зорилт, чиг үүрэгтэй холбон авч үзэж дүгнэж байх, суурь, урсгал зардлын хэм хэмжээг тогтоох, өсөлтийг хязгаарлах боломжийг судлах, захиалгаар авч буй гадаад хэл дээрх мэдээ, судалгааг орчуулж, олон нийтийн хүртээл болгож байхыг зөвлөв. Мөн Монголбанкны нийт системд хэрэглэж буй мэдээллийн технологи, мэдээллийн багцыг арилжааны зарим банкны тэргүүн туршлагатай зэрэгцүүлэн үзэх, технологийн шийдэл, программ хангамжийн банк, санхүүгийн үзүүлэлтүүд, өгөгдөлд дүн шинжилгээ хийх зэрэг асуудлыг хэлэлцжээ. Татан буугдсан Хадгаламж банк, Зоос банк дахь Банкны эрх хүлээн авагчийн тайлан, мэдээллийг Монголбанкны Хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцээд Монголбанк, түүний хяналт шалгалтын газраас эдгээр эрх хүлээн авагчдын ажилд өгсөн мэргэжлийн дүгнэлттэй танилцсаны дараа дахин ярилцахаар болов.



“Mongolia Gold-2019” алтны салбарын хөрөнгө оруулалт, технологийн 3 дахь удаагийн олон улсын чуулга зохион байгуулагдав

2019.03.22



Энэ удаагийн чуулганыг “Нөхөн сэргээлтийг хөгжлийн шинэ шатанд гаргая, алтны нөөцийг нэмэгдүүлье” уриатайгаар зохион байгууллаа. Уг чуулга уулзалтад Монголбанк оролцож, Монголбанкны алт худалдан авалтын өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Монголбанкинд алтаа тушаахын давуу тал, алт тушаалттай холбоотой бусад асуудлаар оролцогчдод мэдээлэл, танилцуулга хийлээ.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Азийн хөгжлийн банктай санамж бичиг байгууллаа

2019.03.22

Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, санхүүгийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, банкны хариуцлага чадамжийг дээшлүүлэх, төрийн зохицуулагч байгууллагын хяналтыг шинэ түвшинд гаргах зорилго бүхий техникийн туслалцааг 2019 оноос 2021 оныг хүртэл 2 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр санамж бичиг байгуулаад байна. Энэ хүрээнд Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан банкны харицлагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах Монголбанкны үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулах, түүний ажилтныг сургах, санхүүгийн маргааныг шүүхийн бус журмаар хурдан шуурхай шийдвэрлэх тогтолцоо буюу бие даасан санхүүгийн омбудсман байгуулах, санхүүгийн боловсрол олгоход анхаарч ажиллахаар тохиролцов.

Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөл хуралдав

2019.03.25

Хамтын ажиллагааны зөвлөлийн ээлжит хуралдаанаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх Ази, Номхон Далайн бүсийн байгууллага /APG/-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд 2 дахь удаа хийсэн Харилцан үнэлгээний тайлангийн ул мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв. Мөн үүнд тулгуурлаж, цаашид хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын талаар хэлэлцэн байр сууриа илэрхийлэв.



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам батлагдав

2019.03.26



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2018 оны 4 дүгээр сарын 26-нд нэмэлт, өөрчлөлт орсон өөрчлөлтийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А-26 тоот тушаалаар “Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулж, Монголбанкны Хяналт шалгалтын газрын Тусгай хяналтын албанаас нийт арилжааны банкны холбогдох мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар тус журамд орсон шинэ зохицуулалтууд, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар танилцуулж, зөвлөмж өглөө. Энэхүү журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.14 дэх хэсэгт заасны дагуу тус хуулийн 4.1 дэх хэсэгт заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаа, үүргийг нарийвчлан тодорхойлоход зорьж байгаа юм.

Банкны салбарын 95 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хурал болов

2019.03.29

Монголбанк, Монголын банкны холбоо хамтран хэрэгжүүлж буй “Банкны хөгжил-95 жил” аяны хүрээнд эдийн засаг, статистик, санхүүгийн чиглэлээр ажиллаж буй мэргэжлийн судлаачид болон тус чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа. Энэ удаа 40 гаруй бүтээл ирснээс эцсийн шатны шалгаруулалтад нийт 10 бүтээл шалгарсан бөгөөд эдгээрээс оюутан болон судлаачдын ангилалд тус бүр шилдэг 3 бүтээлийг шилдгээр шалгаруулж, урамшуулав. Монголбанкнаас жил бүр судлаач, оюутнуудын дунд эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулдаг бөгөөд энэ онд банк санхүүгийн салбарын 95 жилийн ойн хүрээнд зохион байгуулснаараа онцлог байв.





ЭДИЙН ЗАСАГТ ГАРСАН НААШТАЙ ҮР ДҮНГ УЛАМ БАТЖУУЛЖ, ТОГТВОРЖУУЛАХЫГ ДЭМЖИНЭ

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхантай ярилцлаа.

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ
2018 ОНД 6.9% БАЙВ.
ТА ЭНЭХҮҮ ӨСӨЛТӨД
ҮЗҮҮЛСЭН ГАДААД
ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨГ
ХЭРХЭН ДҮГНЭЖ, ИРЭХ
ОНЫ ХАНДЛАГА ЯМАР
БАЙНА ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА
ВЭ?**

Манайх шиг жижиг, нээлттэй эдийн засгийн хувьд эдийн засгийн өсөлтөд үзүүлэх гадаад орчны нөлөө маш их байдаг. Монгол улсын хувьд дэлхийн зах зээл дээрх голлох экспортын түүхий эдийн үнэ, худалдааны түнш орнуудын эдийн засгийн нөхцөл байдал зэрэг нөлөөг үүнд дурдаж болно. Учир нь

Монгол улсын нийт экспортын 90 орчим хувийг зөвхөн уул уурхайн салбар дангаараа бүрдүүлж байна. 2018 он гадаад худалдааны хувьд онцлог жил болж өнгөрлөө. Монгол улс түүхэнд байгаагүй дээд буюу 7.0 тэрбум ам.долларын экспорт хийсэн нь 2017 оныхтой харьцуулахад 800 сая ам.доллараар, 2016 оныхоос даруй 2.1 тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд үнийн болон биет хэмжээний өсөлт аль аль нь нөлөөллөө. Тухайлбал, дэлхийн зах зээл дээрх нэг тонн зэсийн үнэ 2017 онд дунджаар 6,166 ам.доллар байсан бол 2018 онд 6,530 ам.доллар, чулуун нүүрсний хилийн үнэ 2017 онд дунджаар нэг тонн нь 69 ам.доллар байсан бол 2018

онд дунджаар 78 ам.доллар байсан зэрэг голлох түүхий эдийн үнэ өнгөрсөн 2018 онд өндөр өсөлттэй байлаа.

2019 оны 1 дүгээр сарын байдлаар зэсийн үнийн хувьд бага зэргийн бууралт ажиглагдаж байгаа хэдий ч, чулуун нүүрсний үнэ 80 ам.доллар буюу өмнөх жилийн өндөр өсөлтийг хадгалсан хэвээр байна. Тоо хэмжээний хувьд нүүрсний экспорт 36 сая тоннд хүрсэн нь хамгийн оргил хэмжээ болж, 16 хувийн өсөлттэй гарсан бөгөөд энэ онд ч мөн энэ дүн хадгалагдах төлөвтэй. Экспортын энэхүү өсөлт нь дотоодын эдийн засгийн идэвхжилийг бий болгоод зогсохгүй, бусад салбарт эерэг

" Шаардлагатай тохиолдолд банкны салбарт бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг ч авах болно." "

дам нөлөөг үзүүлээ. Мөн МАА-н салбарын бүтээгдэхүүний экспорт түүхэн дээд түвшинд буюу 477 сая ам.долларт хүрсэн нь энэ салбарын нөөц боломж их байгааг харуулж байна. Цаашид ч энэхүү салбарын өсөлтийг хадгалах, дэмжих болно.

**ХУДАЛДААНЫ СУВГААС
ГАДНА МАНАЙ УЛСАД
ГАДААД УЛСУУДЫН
ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ БОЛОН БУСАД
САНХҮҮЖИЛТИЙН ОРОХ
УРСГАЛ НЭМЭГДЭЖ
БАЙНА. ҮҮНИЙ ҮР
НӨЛӨӨГ ТА ХЭРХЭН
ДҮГНЭЖ БАЙНА ВЭ?**

2018 он санхүү, хөрөнгө оруулалтын орчны хувьд таатай жил боллоо. Тухайлбал, хамгийн сүүлийн байдлаар Стандарт энд Пүүрс (S&P) агентлаг манай улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B-" байсныг "B" болгон дээшлүүлсэнд бид өнгөрсөн онд Чингис болон Дим Сам бондын үндсэн төлбөрүүдийг амжилттай төлж барагдуулсан, Монгол улсын ШХО-ын орох цэвэр урсгал 2018 онд 1.9 тэрбум ам.доллар байсан зэрэг нөлөөлөв. Үүнтэй уялдан хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдсэн, ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт амжилттай хамрагдаж ОУВС төдийгүй, бусад оронтой эдийн засгийн хувьд нааштай хэлэлцээрүүдийг хийснээр энэ он болон ирэх онд ч Монголыг чиглэсэн хөрөнгийн урсгал өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй байна. Уг орох урсгал нь валютын нөөцийг нэмэгдүүлэх, гадаад валютын захын тогтвортой байдлыг хадгалах, үйлдвэрлэл, худалдааг дэмжих гээд давхар давхар ач холбогдолтой тул бид хөрөнгө оруулалтын орчинг

илүү таатай болгох, улс төрийн тогтвортой байдлаа хадгалах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай юм. Үүнээс гадна ШХО нэмэгдэхийн хэрээр нөгөө талдаа манай улсын гадаад өр төлбөр нэмэгдэнэ. Тиймээс ШХО-ын үр ашгийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарлаа хандуулах хэрэгтэй. Уул уурхайгаас бусад салбараа хөгжүүлэхэд анхаарч, бусад салбараар дамжих хөрөнгө оруулалтын орох урсгалыг нэмэгдүүлэхэд анхаарна.

**ТАНЫ БОДЛООР ЭДИЙН
ЗАСАГ 2019 ОНД ЯМАР
БАЙХААР ТӨСӨӨЛӨГДӨЖ
БАЙНА ВЭ?**

2019 оны эдийн засгийн өсөлтийг өнгөрсөн жилийн өсөлттэй адил гэсэн таамаглал байна. Учир нь 2019 онд эдийн засгийн орчин харьцангуй эерэг дүр зурагтай байхаар ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, 2017-2018 онд хийгдсэн томоохон хөрөнгө оруулалтуудын үр нөлөө 2019-2020 оны эдийн засгийн өсөлтөд сайнаар нөлөөлөх байх. Аж ахуйн нэгжүүдийн том хөрөнгө оруулалтын зардал бага байж, өмнө нь хийгдээд байгаа үндсэн хөрөнгүүдээ ашиглаад явна. Түүнчлэн эргэлтийн хөрөнгийн санхүүжилтүүд нь банкны зээлээр дамжин тасралтгүй хийгдээд явах нөхцөл бүрдэж байгаа. Иргэдийн хэрэглээний зориулалттай байсан зээлүүд нь аж, ахуйн нэгжүүдийн бизнес рүү илүүтэй чиглэнэ. Банкны системээс эдийн засагт нийлүүлэх зээлийн өсөлт нь 2019 онд өмнөх онтой адилаар 20 орчим хувьтай байх болов уу. Тиймээс дотоод орчинд санхүүжилтийн эх үүсвэр эдийн засгийг тэтгэх боломжтой, гадаад орчны хувьд түрүүн хэлсэнчлэн гол түүхий эдийн үнэ боломжийн түвшинд хадгалагдана.

МОНГОЛБАНК ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ХЭРХЭН ХУВЬ НЭМРЭЭ ОРОУЛЖ БАЙНА ВЭ?

Монголбанк сүүлийн 2 жилд макро эдийн засгийг тогтворжуулж, тулгараад байсан хүндрэлүүдийг богино хугацаанд хохирол багатай даван туулахад гол анхаарлаа хандуулан ажиллалаа. Монголбанк инфляцийг дунд хугацаанд Төв банкны зорилтот түвшинд нийцтэй байхаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, бодит эдийн засгийн идэвхжилийг дэмжиж байна. Аливаа бодлогын үр нөлөө шууд тусгалаа олдоггүй, тодорхой цаг хугацааны дараа үр дүн нь бодитоор харагддаг л даа. Монголбанкнаас 2016 оны эхэнд 15 хувь байсан бодлогын хүүг 2018 он гэхэд 10 хувь болтол үе шаттайгаар бууруулснаар нийт эдийн засаг дахь эрэлтийг нэмэгдүүлж, бодит үйлдвэрлэлийг өсгөх боломжийг бүрдүүлэх чиглэлд анхаарч ажилласан. Энэхүү бодлогын үр дүнд банкуудаас иргэд, компаниудад олгож буй зээлийн жигнэсэн дундаж хүү 2019 оны 1 дүгээр сарын байдлаар жилийн 17.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад л 2.1 нэгж хувиар буурсан байна. Банкуудын зээл олголт 2019 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн. Ялангуяа өрх гэрээс бусад секторт буюу аж ахуйн нэгж, байгууллагуудад олгосон зээл 46 хувиар өссөн байна. Эдгээр тоон үзүүлэлт нь төв банкны хэрэгжүүлж буй мөнгөний болон макро зохистой бодлого, банкны салбарыг шинэчлэх реформын нөлөө, үр дүнг харуулж байна. Төв банкны зүгээс зах зээлд оролцогчдын итгэлийг алдахгүй, хүлээлтийг хамгаалахад гол анхаарлаа хандуулах нь

хамгийн чухал байдаг. Энэ хүрээнд олон нийттэй харилцах харилцаагаа сайжруулж, хүлээлтийг удирдахад чиглэсэн арга хэмжээг авсаар байна.

БАНКУУДЫН ОЛГОЖ БУЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ ӨСӨХИЙН ХЭРЭЭР ИРГЭДИЙН ӨРИЙН ДАРАМТ НЭМЭГДЭЖ БАЙГАА ЮУ? МОНГОЛБАНК 2018 ОНД МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭД ХЭДЭН ШИЙДВЭР ГАРГАЖ, 2019 ОНЫ ЭХНЭЭС МӨРДӨЖ БАЙГАА, УГ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ ЯМАР БАЙДАЛТАЙ БАЙНА ВЭ?

Мөнгөний бодлогын үндсэн арга хэрэгсэлтэй уялдуулан макро зохистой бодлогын арга хэмжээнүүдийн зорилго нь иргэдийн хэрэглээний зээлээс шалтгаалж буй өрийн дарамтыг бууруулах, эдийн засагт эрсдэл үүсэхээс сэргийлэх, цаашид тогтвортой өсөлтийн орчныг хадгалахад чиглэв. Тухайлбал, иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа болон зээлийн хугацаанд дээд хязгаар тогтоосон. Энэ нь иргэдийг өрийн дарамтад орох эрсдэлээс сэргийлэхийн зэрэгцээ банкуудын зээл олголтын бүтцийг иргэдийн хэрэглээний зээлээс бизнесийн зээл рүү шилжихэд нөлөөлж, улмаар бизнес эрхлэгчдийн дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдэж, үйл ажиллагаа нь өргөжин, ажлын байр, үйлдвэрлэл нэмэгдэхэд чухал түлхэц болж байна.

Энэхүү бодлогын үр нөлөө ч эхнээсээ ажиглагдаж эхлээд байна. Банкны салбараас олгосон

нийт зээл 2019 оны 1 дүгээр сарын байдлаар 17.1 их наяд төгрөг байна. Үүнээс ойролцоогоор 58 хувь нь аж ахуйн нэгж, иргэдийн бизнесийн зээл, үлдсэн нь иргэдийн ипотека, цалин, тэтгэвэр гэх мэт хэрэглээний зээл байна. Иргэдийн хэрэглээний хувьд 2018 оны 4 дүгээр улиралд маш өндөр буюу жилийн 50-иас дээш хувиар өсч байсан бол 2019 оны эхний 2 сарын турш иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт саарч байна. Харин бизнесийн зориулалттай олгосон зээлийн жилийн өсөлт 2019 оны 1 дүгээр сарын байдлаар 15 хувь байгаа нь өмнөх оны мөн үед гарч байсан үзүүлэлтээс нэмэгдсэн байна.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ ДЭЭР МОНГОЛБАНК ЯМАР БАЙР СУУРЬТАЙ БАЙГАА ВЭ?

Ипотекийн зээл нь улсын төсөв, Монголбанк, арилжааны банк гэсэн гурван эх үүсвэрээс санхүүжиж байгаа. Дэлхийн банк, ОУВС-тай тохиролцсоны дагуу Монголбанк 2018 онд ипотекийн зээлийн хөтөлбөрийг өөрийн өмчлөлийн Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын зөвхөн үндсэн төлбөрийн орлогоор сар бүр 16 тэрбум төгрөг, нийт 191.36 тэрбум төгрөгийг банкуудаар дамжуулан олгосон. Түүнчлэн Засгийн газартай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу улсын төсөвт тусгасан 120 тэрбум төгрөгийн Засгийн газрын эх үүсвэрийг банкуудад олгоод байна. Монголбанк болон Засгийн газрын 310 тэрбум төгрөгийн эх үүсвэрээс 4700 орчим зээлдэгчийн санхүүжилтийг 2018 онд банкуудад олгосон.

Он гарснаас хойш Монголбанк ипотекийн зээлийн хөтөлбөрийн

хүрээнд 2 дугаар сард 15.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 210 иргэнд олгож, оны эхнээс өссөн дүнгээр 31.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийт 487 зээлдэгчид олгоод байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ИРГЭДИЙН АМЬДРАЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙНА ВЭ?

Эдийн засгийн өсөлтийн эерэг үр дагавар нь өнгөрсөн онуудтай харьцуулахад ажилгүйдлийн түвшний бууралт, дундаж цалин, айл өрхийн орлогын өсөлт, хэрэглээний зардлууд болох хэрэглээний импорт, манай улсаас гадаад руу аялж буй жуулчдын тоо болон аяллын импортын өсөлт зэргээс харагдаж байна.

Тухайлбал, өрхийн дундаж орлого 2018 оны эцсийн байдлаар 2017 оноос 16.9 хувиар нэмэгдэн 1.1 сая төгрөгт хүрсэн байна. Харин ажилгүй иргэдийн тоо 2017 оноос 11.4%-иар буурч 89.9 мянгад хүрч, ажилгүйдлийн түвшин 0.7 нэгж хувиар буурч 6.6%-д хүрчээ. Гадаадад аялагчдын тоо 282 мянгад хүрч өмнөх 7 жилийн дунджаас 34%-иар өсч, хэрэглээний бүтээгдэхүүний импортын жилийн өсөлт 28% -д хүрч, 2017 оноос 17 нэгж хувиар нэмэгдсэн байна. Автомашин, сэлбэг хэрэгслийн импорт 2017 оноос 52% өсчээ. Эдгээр статистик мэдээллээс харахад эдийн засаг сэргэж, эдийн засагт оролцогчдод шууд болон

дам байдлаар тодорхой хэмжээний эерэг нөлөөллийг өгч байгаа гэж үзэж байна. Гэхдээ дээрх статистик мэдээллийг задалж авч үзэх юм бол эдийн засгийн өсөлт цөөн хэдэн салбарын, тодруулбал, уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийн өндөр өсөлтөөс шалтгаалжээ. Үр өгөөж ч гэсэн бүтээж буй салбаруудаасаа болж харилцан адилгүй хуваарилагдаж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, миний түрүүн дурдсан ажил эрхлэлт, цалин, өрхийн орлого ч тодорхой цөөн салбарын хувьд өндөр өсөлттэй гарч байна.

Эдийн засгийг солонгоруулж, төрөлжүүлэх, эдийн засаг сэргэж буй байдлыг аль болох тогтвортой удаан хугацаанд хадгалах, эдийн засгийн өсөлтийг бүтээж буй болон бүтээх иргэдийн боловсрол, мэдлэг, чадварыг сайжруулах асуудал чухал болж байна.

ТА 2019 ОНЫГ СОРИЛТОД БЭЛТГЭХ ЖИЛ БОЛГОНО ГЭЖ ЯРЬСАН БАЙСАН. ЭНЭ ТАЛААР ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР ӨГӨӨЧ.

Түрүүн дурдсанаар 2018 он макро эдийн засгийн хувьд сэргэлттэй сайн жил болж өнгөрсөн, 2019 оны хувьд ч гэсэн экспортын орлого, ГШХО, банкны салбарын зээлийн нийлүүлэлт, төсвөөс хийгдэх хөрөнгө оруулалтууд зэргээс хамааран эдийн засгийн өсөлт үргэлжилнэ гэсэн төсөөлөлтэй

байгаагийн зэрэгцээ томоохон өр төлбөр хийх хуваарь байхгүй. Гэхдээ Монгол Улсын нийт гадаад өр 2018 оны эцэст 28.7 тэрбум ам.доллар байгаа нь ДНБ-ий 217 хувьтай тэнцэх хэмжээнд байгаа нь бидэнд гадаад өр төлбөрийн эрсдэл өндөр хэвээр байгааг сануулсаар байна. Мөн дэлхийн эдийн засгийн удаашрал, 2020 оноос эхлэн төлөгдөх томоохон өр төлбөрүүд зэргээс хамаарч цаашид давж гарах олон томоохон сорилт тулгарч болзошгүй тул 2019 он сорилтод бэлтгэх жил болно. Мэдээж эдийн засагт гарсан нааштай үр дүнг улам батжуулах, тогтворжуулахад тал бүрээсээ анхаарч ажиллаж байна.

Банкны салбарын хувьд Монголбанкнаас реформ, шинэчлэлийн ажлуудыг үргэлжлүүлэх, тухайлбал, одоо хийгдэж буй эрсдэлд суурилсан хяналт шалгалт явуулах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлснээр санхүүгийн тогтворгүй байдал бий болохоос сэргийлж, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, 2019 он Монголын банкны салбарыг эрүүл чийрэг болгохоор ажиллаж байна. Шаардлагатай тохиолдолд банкны салбарт бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг ч авах болно.

БИДЭНТЭЙ ЯРИЛЦСАНД БАЯРЛАЛАА!




Монгол Улсын Экспортын бүтэц




2019 оны 02-р сар

Энэ оны эхний 2 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23%-иар буюу 367 сая ам.доллараар өсч 1,931 сая ам.доллар байв. Үүнд экспорт 30%-иар буюу 255 сая ам.доллараар, импорт 15%-иар буюу 111 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 144 сая ам.доллараар өсч 256 сая ам.долларын ашигтай байна. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.6 нэгж хувиар буурсан байна.


Гадаад худалдааны үзүүлэлтүүд (сая ам.доллар)



Томоохон экспортлогч орнууд



Экспортын зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн (мянган тонн)



Олон улсын
санхүүгийн гэмт хэрэгтэй
тэмцэх байгууллага /
FATF/- аас зарладаг
эрчимжүүлсэн хяналтад
байгаа улс орнуудаас
болон тэдгээр орон руу
гүйлгээ хийх тохиолдолд
гадаадын банкууд
нарийвчлан шалгах,
нэмэлт тодруулга, баримт
мэдээлэл авах зэрэг арга
хэмжээг авч байгаа юм.
Тухайн харилцагч болон
гүйлгээний мэдээлэл,
утга зориулалт нь төлбөр
дамжуулагч, эсвэл төлбөр
хүлээн авагч банкны
дотоод бодлого, дүрэм
журамд нийцэхгүй байх
тохиолдолд төлбөрийг
дамжуулах, хүлээн
авахаас татгалзаж
цуцлах, буцаах, хураах
хүртэл арга хэмжээг
авч байгаа тул банкууд
гүйлгээ хийхдээ эх
үүсвэрийг сайтар нягтлах
шаардлага гарч байгаатай
холбогдуулан ямар арга
хэмжээ авч ажиллаж
байгаа талаар болон үүсч
буй хүндрэлийг хэрхэн
шийдвэрлэж болох тухай
"Байр суурь" буланд
онцоллоо.



А.ДЭЛГЭРСАЙХАН

МБХ-ны Комплайнсын мэргэжлийн
зөвлөлийн дарга, ХХБ-ны
Комплайнсийн хэлтсийн захирал

Бидэнд дотоод дүрэм, журмаа хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлага нэн тэргүүнд тулгарсан. Дараа нь харилцагчдадаа тавих шаардлагаа шинэчлэн тодорхойлсон. Харилцагчид ч шаардлагуудыг эерэгээр хүлээн авч, банкуудтайгаа хамтран ажиллаж байгаа нь давуу тал юм. Өнөөдөр банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээндээ баримталж буй хамгийн гол зарчим бол "Харилцагчаа таньж мэдэх" болсон. Харилцагчаа таньж мэдэх гэдэг нь данс нээх, гүйлгээ хийх үйлчилгээ үзүүлэхийн өмнө хэнд, ямар үйлчилгээ үзүүлж байгаа талаар бүрэн дүүрэн мэдээллийг харилцагчаас авах юм. Тиймээс шаардлагатай мэдээ мэдээлэл, баримтыг харилцагчаас авах, сайн программ хангамж нэвтрүүлэх, оновчтой хяналт хийх, ажилтнуудаа сургаж, мэргэшүүлэх тал дээр арилжааны банкууд илүүтэй төвлөрч ажиллаж байна. Банкууд тус бүртээ, өдөр тутамдаа гадаад төлбөр тооцоонд үүсч болзошгүй эрсдэлийн талаар харилцагчиддаа мэдээлэл зөвлөгөө өгөх, олон улсын байгууллагуудын дүрэм журмыг танилцуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарал тавьж ажиллаж байна.



ТОРСТЕН КЛАЙН БОЙНИНГ

ХАС банкны Эрсдэл хариуцсан захирал

Харилцагчийг таньж мэдэх талаар олон улсын шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд Монгол Улс нь гадаад төлбөр тооцооны арга хэрэгсэлгүй болох эрсдэлтэй. Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх чиглэлээрх олон улсын хэм хэмжээний талаарх мэдлэгийг монголын банкууд харилцагчиддаа хүргэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна. Тиймээс хэд хэдэн асуудлуудад голлон анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд: Зохицуулагч байгууллагаас банкуудаад тодорхой эрх зүйн заавар, чиглэл өгөх, авилга хээл, хахууль болон мөнгө угаах хэргүүдийг шүүхийн системээр дамжуулан шийдвэрлэх ба Комплаенсийн хууль тогтоомжийг тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй гэх зэрэг юм.

**Л.АМАР***Азийн хөгжлийн банкны Эдийн засагч*

Санхүүгийн зах зээл буюу банкнаас бусад салбарт мөнгө угаах эрсдэл олон улсын туршлагаас харахад өндөр байна. Бохир аргаар их хэмжээний бэлэн мөнгөтэй болсон хүмүүс мөнгөө ББСБ-аар дамжуулан угаах, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, валют болгон солих эрсдэлтэй байна. Даатгалын салбар, үнэт цаасны компаниуд ч энэ эрсдэл дунд байгаа тул хэрэглэгчээ таних нь маш чухал үйл явц. Хар жагсаалтад орж, олон улсын хоригт багтсан Иран, Умард Солонгос улсуу гүйлгээ хийхгүй байх ёстойгоо мэдэж байх шаардлагатай.

**Т.ТҮВШИНБАЯР***Витафит группийн санхүүгийн менежер*

Сүүлийн үед ялангуяа, ам.доллараар гадаад гүйлгээ дамжуулахад банкуудын зүгээс манай бизнесийн үйл ажиллагаа болон хүлээн авагчтай байгуулсан гэрээ, холбоо хамаарал зэрэг маш нарийн мэдээллийг шаарддаг болсон байна. Энэ нь зөвхөн дотоодын банкнаас тавьж буй шаардлага биш, олон улсын төлбөр тооцооны системийн хэмжээнд тавигдаж буй шаардлага гэдгийг ойлгосон. Учир нь хууль ёсны бизнес эрхэлж байгаа гэдгээ, мөн аливаа хууль бус, гэмт хэргийн замаар олсон мөнгөн хөрөнгийг банкаар дамжуулаагүй гэдгээ үйлчлүүлж буй банкиндаа болон гадаад төлбөр тооцоо дамжуулагч банкинд батлах, шаардсан мэдээллийг гаргаж өгөх нь гадаад төлбөр тооцоог саадгүй дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх тул шаардлагатай мэдээллийг цааргалалгүй өгч байх нь харилцагчид л тустай.

**Н.МЯГМАРСҮРЭН***Нэкст электроникс ХХК-ын Ерөнхий нягтлан бодогч*

Сүүлийн үед арилжааны банкууд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хүрээнд харилцагчдыг салбар тооцооны төвд ирж мэдээллээ шинэчлүүлэх, гадаад төлбөр тооцоотой холбоотой нарийн мэдээллээ гаргаж өгөх шаардлага тавих болсон. Надад мессеж ирсний дагуу, банкинд очиж мэдээллээ шинэчлүүлсэн. Банк нэг талаасаа харилцагчийн төлбөр тооцоог хийж өгдөг үйлчилгээний байгууллага боловч нөгөө талаасаа дэлхий даяар тархсан төлбөр тооцооны системийг эрүүл байлгах, аливаа гэмт хэргийн гаралтай болон хууль бус мөнгө банкинд байрших, дамжуулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэг хүлээдэг тул энэхүү үүргээ биелүүлж байж олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай саадгүй харилцаж чадна гэж харж байна.



1959 ГҮЙЛГЭХНИЙ 2000Ч МӨНГӨ

1959 онд 1, 2, 5, 10, 15, 20-н мөнгөний нэрлэсэн үнэтэй зоосыг БНХАУ-д үйлдвэрлэн гүйлгээнд гаргажээ.

1, 2, 5 мөнгө нь голдоо нүхтэй өвөрмөц хийцтэй үйлдвэрлэгдсэн.

Нүүр тал: Тариан түрүү дүрслэн дээр нь “мөнгө” гэж кирилл үсгээр, голын нүхний дээд талд нэрлэсэн үнийг бичсэн.

Ар тал: Голын нүхийг тойруулан улсын нэрийг кирилл үсгээр, оныг араб тоогоор бичсэн.





МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ГАЗАР

Мөнгөн тэмдэгтийн газар нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан үндэсний мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор дараах чиг үүргийг эрхэлнэ.



1. Мөнгө хэвлэх, гүйлгээнд гаргах, буцаан татах

Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээ татах замаар гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг хангах; Мөнгөн тэмдэгт шинээр үйлдвэрлэх, тээвэрлэх, түүний нөөцийг бий болгох;

2. Үндэсний мөнгөн тэмдэгтийн нөөц бүрдүүлэх, хадгалах, хамгаалах

Үндэсний мөнгөн тэмдэгтийн Нөөц болон Төв бэлтгэл сангийн найдвартай, тасралтгүй ажиллагааг болон тэдгээрийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангах;



New & Improved!

3. Сайжруулах, шинэчлэх

Үндэсний мөнгөн тэмдэгтийн чанар, үзэмж, хамгаалалтын таних тэмдгийг олон улсын шинэ дэвшилтэт технологи, дэлхий нийтийн хөгжил дэвшилтэй уялдуулан тогтмол сайжруулж, боловсронгуй болгох;

4. Болоого боловсруулах

Үндэсн чиг үүрэгтэй холбогдсон журам, шавар боловсруулах, мөрдөх, Үндэсн чиг үүрэгтэй холбогдсон бодлогын санал боловсруулах;



5. Үндэсний мөнгөн тэмдэгтийг таних

Мөнгөн тэмдэгтийн хүчин төгөлдөр, хуурамч эсхийг тодорхойлох, гэмтэж мууссаныг солих, устгах ажлыг эрхлэн зохион байгуулах;

6. Хуучны үнэт мөнгөн тэмдэгтийг хадгалах, хамгаалах

Гүйлгээнээс хасагдсан хуучны үнэт мөнгөн тэмдэгтүүд, зогшууул болон дурсгалын зориулалттай бусад мөнгөн тэмдэгтийн нөөцийг хадгалах, зарцуулах, тэдгээртэй холбоотой журам, шаар баримт бичиг мөрдөх;



НӨӨЦ НЬ БАГАСЧ БУЙ МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ ДАХИН ХЭВЛЭХ НЬ ТӨГРӨГИЙГ ҮНЭГҮЙДҮҮЛЭХ ШАЛТГААН БОЛОХГҮЙ



Энэ удаагийн дугаартаа Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газрыг танилцуулахаар Мөнгөн тэмдэгтийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах эдийн засагч Г.Дуламсүрэнтэй ярилцсанаа толилуулж байна.

**ТАНТАЙ МӨНГӨН
ТЭМДЭГТИЙГ ЯМАР
ШААРДЛАГААР ХЭВЛЭДЭГ
БОЛОХ, ТҮҮНИЙ
НАСЖИЛТ, БҮТЭЦ ГЭХ
МЭТ СЭДВИЙН ДОР
ЯРИЛЦАХЫГ ХҮСЧ БАЙНА.
ТИЙМЭЭС ЭХЛЭЭД
ТАНАЙ ГАЗРЫН ӨДӨР
ТУТАМД ХИЙДЭГ АЖЛЫН
ОНЦОГООС ЯРИЛЦЛАГАА
ЭХЛЭЕ.**

Мөнгөн тэмдэгтийг хэвлэх бас устгах цор ганц үүргийг Төв банк гүйцэтгэдэг шүү дээ. Манай газрын хувьд энэ үүргийг хэрэгжүүлдэг. Бидний өдөр тутамд хийгддэг ажлын гол онцлог бол гүйлгээнд бэлэн мөнгө гаргах, гүйлгээнээс татах, тушаагдсан мөнгөн дэвсгэртүүдийг сайн муугаар нь ялгаж, элэгдэж, хуучирсан, шаардлага хангахааргүй болсон дэвсгэртүүдийг утсгалд оруулж, шинэ дэвсгэртээр солих зэрэг ажлууд байдаг. Мөнгө хэвлэх тухайд бол Монголбанкны мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрхийг хэрэгжүүлэхдээ аливаа мөнгөн тэмдэгт шинээр хэвлэхийн

өмнө байгаа нөөцөө судалж, хэдий хэмжээний нөөцийг хэр удаан хугацаанд гүйлгээнд гаргах вэ гэдэг тооцоо, судалгааг хийж байж уг тооцоолол дээр үндэслэн аль дэвсгэртийг, хичнээн тоо ширхгээр үйлдвэрлэхээ тогтоодог доо.

**ЭНЭ НЬ САНХҮҮЖИЛТ
ХИЙХ ЗОРИЛГООР МӨНГӨ
ХЭВЛЭХТЭЙ АДИЛ УУ?**

Адил биш юм аа. Харамсалтай нь олон нийтийн дунд мөнгө хэвлэх тухайд хэт туйлширсан, буруу ойлголт яваад байдаг. Тухайлбал, саяханы жишээ буюу Монголбанк 5000 төгрөгийн дэвсгэртийг хуурамчаар үйлдэхээс хамгаалж, таних тэмдгийг нь дэвшилтэт технологиор шинэчлэн сайжруулж 2019 оны эхнээс гүйлгээнд нэвтрүүлсний дараа олон нийтийн сүлжээнд “мөнгө хэвлэлээ” гэсэн шүүмжлэл мэр сэр гарсан. Гэтэл энэ дэвсгэртийн хувьд нөөцийнх нь тооцооллыг хийсний үндсэн дээр 2017 онд шинээр хэвлэх шийдвэр нь гарч 2018 онд үйлдвэрлэгдсэн байдаг юм. Ингэхдээ тухайн үеийн холбогдох хууль журмын дагуу ажиллаж, үйл явц нь 1.5 жил

үргэлжилсэн байна. Ер нь мөнгөн тэмдэгт шинээр хэвлэх явцад хугацаа их ордог. Ялангуяа, шинэчлэн сайжруулсан тохиолдолд гүйлгээнд гаргахын өмнөх бэлтгэл ажлууд шаарддаг. Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгтийн чанар, үзэмж, хамгаалалтын таних тэмдгийг олон улсын шинэ дэвшилтэт технологи, дэлхий нийтийн хөгжил дэвшилтэй уялдуулан сайжруулж, боловсронгуй болгоход чиглэн ажиллаж байна. Уучлаарай! ойлгомжтой тайлбарлахын тулд эхлээд жишээ татах хэрэгтэй байлаа. Тиймээс таны асуусан асуултын хувьд нөөц нь багасч буй мөнгөн тэмдэгтийг дуусахаас нь өмнө дахин хэвлэдэг Монголбанкны хуулиар олгогдсон үйл ажиллагаа нь “шинээр мөнгө хэвлэж гүйлгээнд оруулах нь төгрөгийг улам үнэгүйдүүлж, ханшийг нь унагах” ойлголтоос огт өөр юм.

**ТЭГВЭЛ, ГҮЙЛГЭЭНД
БЭЛЭН МӨНГӨНИЙ
НИЙЛҮҮЛЭЛТ ХЭРХЭН
ХИЙГДДЭГ ЮМ БЭ?**

Монголбанк гүйлгээнд бэлэн мөнгө гаргахдаа зөвхөн эрэлт ирсэн

тохиолдолд буюу банкуудаас бэлэн мөнгө авах хүсэлт гаргаж, захиалга өгсөн тохиолдолд нийлүүлдэг. Ингэхдээ банкууд Монголбанкин дахь өөрийн харилцах дансанд байгаа мөнгөний хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр ямар дэвсгэртээр, хэдий хэмжээний бэлэн мөнгө авах шийдвэрээ өөрсдөө гаргадаг. Шинээр үйлдвэрлэсэн мөнгөн тэмдэгтийг ч мөн энэ журмаар урт хугацаанд аажмаар гүйлгээнд гаргадаг. Тиймээс шинээр хэвлэсэн бэлэн мөнгө гүйлгээнд гаргах энэхүү үйл ажиллагаа нь Монголбанкнаас банкуудад санхүүжилт олгож, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж буй явдал огтоос биш гэдгийг дахин хэлье.

**ҮҮНЭЭС ГАДНА БАС НЭГ
СОНИРХОЖ БАЙГАА
ЗҮЙ БОЛ МӨНГӨН
ДЭВСГЭРТ ЭЛЭГДЭЖ
ХУУЧРАН ГҮЙЛГЭЭНЭЭС
ХАСАГДАХ ХУГАЦААНД
НӨЛӨӨЛӨХ ГОЛ ХҮЧИН
ЗҮЙЛИЙН ТАЛААР ЯМАР
ДҮГНЭЛТТЭЙ БАЙДАГ ВЭ?**

Насжилтын хугацааг улс орнуудын хөгжлийн түвшин, мөн мөнгөн тэмдэгтийг хийсэн материалын ялгаатай байдлаас шалтгаалж тус тусад нь тооцоолсон байдаг. Тухайлбал, хөгжиж буй орнуудын хувьд цаасан мөнгөн тэмдэгт дунджаар 2-3 жил, өндөр хөгжилтэй орнуудад 10-12 жилийн насжилттай байдаг гэсэн судалгаа бий. Мөнгөн тэмдэгтийг хийсэн материалын чанар нь сайн байх тусам өртөг нь өндөр болж байдаг. Өөр гол хүчин зүйл нь байгаль цаг агаар, иргэдийн бэлэн мөнгөтэй харьцах соёл, хэвшил, Төвбанкны бодлого, банк, санхүүгийн салбарын хөгжил зэргээс ихээхэн хамаарна.

Манай улсын мөнгөн

дэвсгэрийн насжилтын талаарх хамгийн сүүлд хийсэн судалгаагаар цоо шинээр гүйлгээнд гаргасан мөнгөн дэвсгэрт дунджаар 4.5 жилийн хугацааны турш идэвхтэй төлбөр тооцоонд хэрэглэгдсэний эцэст элэгдэж хуучран, шаардлага хангахгүй болсноор гүйлгээнээс татагдан устгагдаж байна. Тэгвэл хамгийн богино насжилттай нь 1000 төгрөг байгаа юм. 2.8 жил гүйлгээнд эргэлдэж байна. Харин хамгийн урт нь 6 жилийн насжилттай 10000 төгрөг, 20000 төгрөгийн дэвсгэртүүд болж байна.

Гүйлгээнд хэрэглэгдэж байгаа төгрөгийн чанар байдал ерөнхийдөө маш их муудан өрөөр хэлбэл, хуучирч үнгэгдэн өнгө зүс нь алдагдсан, хиртсэн, урагдсан, туузан наалттай, эсвэл хамгаалалтын элемент нь арилсан гэх мэт гүйлгээнд хэрэглэх шаардлагыг хангахгүй нь их болсон. Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газар шаардлагатай арга хэмжээг авч байгаа хэдий ч олон нийтийн бэлэн мөнгөтэй харьцах соёл, сэтгэлгээг давхар өөрчлөхгүйгээр сайн үр дүнд хүрэхгүй л дээ. Тийм учраас манай газраас бэлэн мөнгөний харилцаанд байнга оролцож байдаг банк, үйлчилгээний байгууллага, иргэдэд хандсан мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээг сурталчилсан сурталчилгаа, мэдээлэл, танилцуулгыг хүргэх зорилготой арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэхдээ энэ асуудал нь цаг хугацаа нэлээд шаардсан, өөрийн гэсэн онцлогтой. Иргэдийн бэлэн мөнгөтэй харьцах хандлага өөрчлөгдөж, соёлтой хэрэглээнд дадаж эхэлсэн ч гэлээ нэгэнт хэдийнээ хуучирч элэгдсэн дэвсгэртүүд нэг хэсэг гүйлгээнд эргэлдэж л байх болно. Учир нь

гүйлгээнд гаргасан нийт бэлэн мөнгөний зөвхөн 30-аад хувь нь л банкны кассаар дамждаг. Зөвхөн энэ хэсэг нь л тодорхой хугацаанд Монголбанкинд ирж ялгагдаж цэгцлэгдэнэ гэсэн үг. Үлдсэн хэсэг нь иргэд, компаниудаар дамжин эргэлдэж байгаад банкинд тушаагдсан үед л муу мөнгөн дэвсгэртийг ялган гүйлгээнд оруулахгүй байх боломжтой юм.

**ГОЛ НЬ ЯМАР ХҮЧИН
ЗҮЙЛС МӨНГӨН
ТЭМДЭГТИЙГ НАСЖИЛТЫГ
БАГАСГАХАД НӨЛӨӨЛЖ
БАЙНА ВЭ?**

Манай иргэдийн дунд түрийвч хэрэглэх байдал нь хангалтгүй, мөнгийг хэд дахин нугалж, үрчийлгэн хаа хамаагүй газраа авч явдаг, зориулалтын бус газарт мөнгөө хадгалснаас болж гал усанд автуулах зэргээр эрсдэл үүсгэж дахин ашиглах боломжгүйд хүргэдэг. Худалдааны газруудад, тэр дундаа мах ногооны худалдагч нар бохирдсон гараараа мөнгөтэй харьцдаг зэрэг зохисгүй үйлдлүүдээрээ мөнгөн тэмдэгтийн чанарыг муутгаж, гүйлгээнд хэрэглэгдэх насжилтыг нь богиносгож байна. Үүнээс гадна жижиг дүнтэй дэвсгэртүүдийн худалдан авах үндсэн үүргийг алдагдуулж, газар, лус тайтгаруулах гэж байна гэж газарт багц багцаар нь булах, суварга овоонд өргөх, тахилга номонд зориулах, агуйд хийх, сугалаанд ашиглах зэргээр хэрэглэж байгаа нь эдийн засагт төдийгүй байгаль орчиндоо ч хортой гэдгийг иргэд маань ухамсарлах хэрэгтэй байна л даа.

Төгрөг бол Монгол Улсын тусгаар тогтнол, түүх, соёл, заншлын билэгдэл. Өвөг дээдэс маань төрийн минь сүлд буй хэмээн мөнгөнд хүндэтгэлтэй хандаж ирсэн



шүү дээ. Төгрөг нь үндэстний үнэт зүйлийн хувьд зөвхөн төлбөр тооцооны зориулалтаар ашиглах ёстой төлбөрийн баталгаат хэрэгсэл гэдгийг л санаж баймаар байна. Мөнгийг бүтээх, үйлдвэрлэх, гүйлгээнд гаргах, тасралтгүй найдвартай хангах, устгагдах хүртэлх үе шат бүрт өндөр өртөг, асар их цаг хугацаа, ихээхэн хүч хөдөлмөр шаардагддаг тул иргэн бүрийн мөнгөө авч явах дадал хэвшил нь зөв, мөнгөнд хандах хандлага нь зүй зохистой бол тэр хэрээр зардал хэмнэгдэх болно.

Дашрамд иргэдийн зайлшгүй мэдэж байх хэрэгтэй, мөнгөн тэмдэгтийн хамгаалалтын талаарх мэдээлэл өгөхийг хүсч байна.

Мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэхээс сэргийлсэн хамгаалалтын таних тэмдэгүүд нь нүдэн баримжаагаар болон мэдрэхүйгээрээ таньж болох усан хээ, металл болон товгор хээ, холограмм зэрэг шууд танигдах элементүүд байдаг бол томруулдаг шил, хэт ягаан туяаны гэрэл зэрэг жижиг багажны тусламжтайгаар таних бичил үг, үсэгнүүд, хялгасан утаснууд, фосфортож буюу гэрэл ойж харагддаг элементүүд байдаг. Тухайлбал 20000 төгрөгийн дэвсгэртүүдийн нүүрэн талын "Монгол Улс" гэж эвхмэл монгол үсгээр бичсэн хэсэг, соёмбо, монгол бичгээр "Монголбанк хорин мянган төгрөг" гэж бичсэн хэсгүүд товгор хэвлэлттэй бөгөөд гараараа барьж имэрч үзэхэд мэдрэгддэг. Гэрлийн эсрэг барьж харахад Чингис хааны хөрөг, МБ гэсэн дүрс усан хээгээр тодорч харагддаг.

Бүр нарийн гэвэл энгийн хүн бус төв банк, шүүх бусад мэргэжлийн байгууллагын лабораторын түвшинд таних боломжтой нууц элементүүд байдаг.

Манай мөнгөн дэвсгэртийн хамгаалалтын элементүүдийг хэрхэн шинэчлэн сайжруулж байсан тухай сонирхуулаач. Ер нь л анзаараад байхад бага багаар өөрчлөгдөөд байдаг шүү дээ.

Манай улсад одоогийн байдлаар ердөө 3 тохиолдол байдаг. Манай улсын мөнгөн дэвсгэртүүд нь 10 орчим төрлийн хамгаалалтын таних тэмдэгтэй байдаг. Зарим хамгаалалтын таних тэмдгийг нь техник технологийн шинэчлэлийг дагаад өөрчлөх, сайжруулах тохиолдол байдаг. Тухайлбал, 20000 төгрөгийн дэвсгэртийг 2006 онд анх хэвлэж гүйлгээнд гаргасан ч 2009 онд дахин хэвлэхдээ хуурамчаар хийхээс сэргийлсэн хамгаалалтыг шинэчлэн сайжруулсан. Ингэхдээ дэвсгэртийн ар талд давхацсан босоо өлзий хээний дунд Төрийн цагаан туг, түүний доор 20000 гэсэн араб, уйгаржин тоог байрлуулсан холограм оруулж өгсөн. Мөн тусгай тунгалаг материалаар хийсэн зуйван дугуй хэлбэрийн цонх үүсгэж, бараан суурин дээр МБ гэсэн үсэг, цайвар суурин дээр 20000 гэсэн уйгаржин тоо тодорч харагддаг зэрэг тусгай технологи ашигласан хамгаалалтын таних тэмдэгтэй болж шинэчлэгдсэн. Дараагийн тохиолдол нь та бүхний мэдэж байгаа саяхны 5000-тын дэвсгэрт юм.

Гадаад орнуудын хувьд харцангуй ойр ойрхон хугацаанд сайжруулж байх жишээтэй. Тухайлбал Европын холбооны банк нь гүйлгээнд өргөнөөр хэрэглэгддэг 5, 10, 20, 50 еврогийн дэвсгэртийг сүүлийн 6 жилийн хугацаанд 4 удаа хамгаалалтын таних тэмдгийг нь сайжруулан дахин хэвлэсэн байдаг.

**ИНГЭЖ ШИНЭЧЛЭХ
ШААРДЛАГА НЬ
ТЕХНОЛОГИЙН**

**ШИНЭЧЛЭЛЭЭ ДАГАДАГ
БАЙХ ГЭЖ БОДОЖ
БАЙНА. ЭСВЭЛ БУРУУ БИ
ОЙЛГОЛТТОЙ БАЙНА УУ?**

Хамгийн гол нь хуурамч мөнгөн дэвсгэрт үйлдэж байгаа байдлаас л болдог. Цагдаагийн байгууллагад бүртгэдсэн хуурамч мөнгөн дэвсгэртийн дийлэнх нь буюу 57.6 хувь нь 20000 төгрөг, 19.7 хувь нь 10000 төгрөг, 14.1 хувь нь 5000 төгрөгийн мөнгөн дэвсгэрт байдаг. Хуурамчаар үйлдэхдээ мөнгөн тэмдэгт хэвлэх тусгай технологи, төхөөрөмж ашиглаж үйлдвэрийн аргаар үйлдвэрлэсэн тохиолдол гараагүй байна. Харин энгийн хувилагч машин ашиглаж, принтерлэх, скайнердах аргаар хуурамч мөнгөн тэмдэгт хийх тохиолдол байдаг.

Хуурамч дэвсгэртийг үйлдэхдээ харахад нүдэнд шууд тусах онцлог хамгаалалтын таних тэмдэг болох Соёмбо, метал утсыг саатай балаар будах, холограмыг дуурайлган гялгар материалаар хийх, 2009, 2013 оны 20000 төгрөгийн дэвсгэртийн тусгай тунгалаг материалаар хийсэн зуйван дугуй хэлбэрийн цонхыг салган авч, хуурамч дэвсгэрт хийхдээ ашиглах зэргээр хийсэн тохиолдлууд гарсан. Мөн зориуд хуучирсан мэт харагдуулахын тулд цаасыг нь үнгэж базаж, элэгдсэн мэт харагдуулдаг. Тэрийг нь усанд норгоход будаг нь уусчихдаг. Бас Чингис хааны хөрөгтэй усан хээг хоёр цаасны голд өөрсдөө гараараа зурах, эсвэл бүдэгрүүлж хэвлэн хавчуулах зэргээр хийсэн байдаг. Мөн дэвсгэртийн нүүрэн талын 20000 гэсэн тоо болон бичиг нь ямар ч товгор хэвлэлтгүй байх, эсвэл өнгөгүй лакаар тус хэсгүүд дээр будах гэх мэтээр хуурамчаар дуурайлгаж хийсэн байдаг. Гэрэл муутай орчинд бол хүн ялгахгааргүй

байгаа учир ил харагдах хамгаалалтын элементүүдийг шинэчлэх шаардлага гарч байна гэсэн үг. Энэ мэт үйлдлээс сэргийлж улам сайжруулдаг.

**МӨНГӨН ДЭВСГЭРТИЙГ
ХУУРАМЧААР ҮЙЛДЭХ,
ХУУРАМЧ ДЭВСГЭРТИЙГ
САНААТАЙГААР ТӨЛБӨР
ТООЦООНД ХЭРЭГЛЭХ
НЬ ХУУЛИЙН ЯМАР
ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАГ
ВЭ?**

Монгол улсын Эрүүгийн хуульд мөнгөн тэмдгийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдэснийг мэдсээр байж ашигласан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 2-5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх заалттай байдаг. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн тохиолдолд ял шийтгэл нь илүү нэмэгддэг.

Дашрамд хэлэхэд “Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам”-ын холбогдох заалтын дагуу хуурамч мөнгөн тэмдэгтийг иргэн, байгууллага хадгалах, устгахыг хориглодог. Монгол улсын нутаг дэвсгэрт хуурамч мөнгөн тэмдэгт илэрсэн тохиолдол бүрт иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь нэн даруй цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, гүйлгээнд оруулахгүй байх үүрэгтэй байдаг.

ЯРИЛЦСАНД БАЯРЛАЛАА.



УЛСЫН БАНКНЫ САЛБАР

ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГА

1924 онд Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн банк байгуулагдав. 1954 онд Зөвлөлтийн тал хувь нийлүүлсэн Худалдаа, аж ахуйн банкинд оруулсан өөрийн хувь хөрөнгөө БНМАУ-ын мэдэлд шилжүүлэн өгчээ.



**Тасрангийн
БАЛДАН**

1906 онд Ашинга харуулын нутагт төрсөн. 1932-1933 онд ЗХУ-д банкны дадлагажилтын курст суралцан төгссөн. 1927 оноос Худалдаа аж үйлдвэрийн банкнаа дансны бичээч, төлөөлөгч, эдийн засагч, 1934 оноос Дорнод аймгийн банкны орлогч эрхлэгч, Сангийн яамны Валютын газрын дарга, 1940 оноос Худалдаа аж үйлдвэрийн банкны Ерөнхий хорооны дарга, 1954-1955 онд Улсын банкны Ерөнхий хорооны дарга, 1955 оноос Хэнтий аймгийн банкны дарга, 1956-1966 онд СнЗ-ийн Хянан шалгах хороонд ахлах байцаагчаар ажилласан. 1975 онд таалал төгсжээ.

Улмаар 1954 оны дөрөвдүгээр сарын 12-нд БНМАУ-ын СнЗ-ийн 102 тоот тогтоолоор Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банкныг өөрчлөн зохион байгуулж, “БНМАУ-ын Банк” гэж нэрлэхээр тогтож, Улсын банкны дүрмийг батлав. БНМАУ-ын банк нь үйл ажиллагааны хувьд СнЗ-д захирагдсан, аж ахуйн тооны журмаар ажиллах, хууль ёсны байгууллагын эрх хэмжээтэй болжээ. “БНМАУ-ын Банкны дүрэм”-д БНМАУ-ын банк (Улсын банк) нь Монголбанкны суурь дээр байгуулагдсан эмиссийн ганц банк бөгөөд богино, урт хугацаатай зээллэгээ олгох, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, тус улсын гадаад, дотоод ажил гүйлгээ эрхлэх тооцооны ба кассын төв болно” гээд банкны зорилгыг үндэсний валют төгрөгийг бэхжүүлэх, үйлдвэрийн ба бараа гүйлгээний төлөвлөгөөний биелэлт, үйлдвэрлэлийн газруудын санхүүгийн төлөвлөгөөний биелэлт, ашиг орлогын явцыг өдөр тутам төгрөгийн хяналтаар хангаж, аж ахуйн тооцоог дэлгэрүүлэх ба бэхжүүлэх, улс ардын аж ахуйд арвилан хэмнэх ёс журмыг сахиулах талаар арга хэмжээг ямагт авч байх, албан үйлдвэрийн газруудын мөнгөн хөрөнгийг хамгийн дээд хэмжээгээр төвлөрүүлэх, улс ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөний үндсэн дээр тус улсын тодорхой мөнгөний эргэлтийг тэгшитгэх богино, урт хугацаатай зээллэг олгох, барилга ба хөрөнгө оруулалтыг улсын хөрөнгө ба үйлдвэр байгууллагуудын өөрсдийн хөрөнгөөр санхүүжүүлэх, ардын үйлдвэрлэлийн нэгдэл, энгийн хүмүүсийн чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хуралдуулах, БНМАУ-ын улсын төсвийн кассын гүйцэтгэлийг биелүүлэх, улсын хийгээд

хоршооллын байгууллага ба үйлдвэрийн газруудын хооронд бэлэн бус мөнгөний тооцоог дэлгэрүүлэх, гадаад харилцаа ба гадаадтай харилцах бусад ажил гүйлгээгээр хийх ажлыг эрхлэх гэж тодорхойлжээ.

Улсын банкны төв аппарат нь түүний Ерөнхий хороо юм. Улсын банкны Ерөнхий хороо нь өөрийн салбаруудын зээл тооцоо, санхүүжилт, бүртгэл, мөнгөний гүйлгээний бүх ажиллагааг зохицуулан явуулахад төвлөрсөн нэгдсэн удирдлагаар хангаж холбогдох заавар, заалт, удирдамжийг гаргадаг байв. Улсын банк нь дүрмийн ёсоор харилцагч байгууллагуудаас заавал биелүүлвэл зохих ажил төрлийн зааврыг боловсруулан гаргана. Мөн Улсын банк нь зээлийн баталгаа болгон барьцаалсан бараа-материалын үнэ бүхий зүйлийн хадгалалтын



УЛСЫН ГАНЦ БАНК

Яармаг дахь баяр наадмын талбайд зассан Худалдаа аж үйлдвэрийн банкны үзэсгэлэнгийн павильон.

байдал аж ахуйн газар байгууллагуудын данс бүртгэл, мөнгөн тооцооны баримтуудыг шалган үзэх эрхтэй байв.

1924 оны намар Улсын банкны анхны салбар Алтанбулаг хотноо 1-р хэлтэс нэртэйгээр нээгджээ. 1925 онд Монголбанк нь орон нутагт дөрвөн салбартай байсан бол 1930 онд банкны хэлтэс, салбарын тоо 19-д хүрч өргөжив. Тухайн үед банкны орон нутгийн ихэнх хэлтэс, салбар гол төлөв эсгий гэрт конторлож, мөнгө, үнэ бүхий зүйлээ хадгалж, шөнө лааны гэрэлд ажилладаг, ажилтан нар ээлжээр манаачтайгаа хамт жижүүр хийдэг, системийн хэмжээгээр бүртгэл тооцооны машин техник байхгүй, хөдөлмөрийн гол багаж хэрэгсэл нь сампин болж байв.

1942 он гэхэд Монголбанк бүх аймгийн төвд үйл ажиллагаагаа явуулах салбар хэлтэстэй болжээ. Улсын банкны салбарууд нь төвлөн удирдах ёс зарчмын үндсэн дээр Улсын банкны Ерөнхий хороонд төвлөрсөн журмаар захирагддаг байв. Улсын банкны орон нутгийн салбар хэлтэс нь зээл, тооцоо, санхүүжилт, касс, бүртгэл мөнгөний гүйлгээний өдөр тутмын ажлыг гардан явуулж байв. Улсын банкны бүрэлдэхүүнд орон нутгийн тооцооны болоод хадгаламжийн кассууд хамаарагдана. Тооцооны касс нь зээл, тооцоо санхүүжилтийн ажлыг гардан явуулахгүй боловч бэлэн мөнгийг хүлээн авч, төсөвт газруудын зардлыг төлөхийн



хамт хөдөлмөрчдийн хадгаламжийн ажлыг эрхлэн явуулах үүрэгтэй байсан юм. Хадгаламжийн касс нь хөдөлмөрчдийн хувийг хадгаламжийг өргөнөөр хуралдуулан цугларуулах үүрэг хүлээж байв. 1954 оны байдлаар Улсын банк нь 22 хэлтэс, салбар, 13 кастай байв. Мөн Улсын банкны салбар хэлтсүүд нь өөрсдийн харьяанд тооцооны ба хадгаламжийн кассуудтай байдаг. Улсын банкны орон нутгийн хэлтсүүд нь Улсын банкны Ерөнхий хороонд шууд захирагдахын зэрэгцээгээр орон нутагт зохиогдож байгаа аж ахуйн олон хэлбэрийн ажилд идэвхтэй оролцож, орон нутгийн нам, захиргааны байгууллагатай нягт холбоотой байж тэдгээрийн өдөр тутмын удирдамжийг авч байдаг. 1964 онд Улсын банкны Ерөнхий хорооны бүтцэд томоохон өөрчлөлт хийж, үйлчилгээний ажлыг тусад нь гаргаж, Улаанбаатар Хотын Банкны салбарыг байгуулав. Түүнчлэн 1965 онд МАХН-ын Төв Хороо, СнЗ-ийн тогтоолоор аймгийн төвөөс 100 км-ээс хол орших сумдад банкны тооцооны касс байгуулахаар болж байв.

1978 онд СнЗ-ийн 228 тоот тогтоолоор аймаг, хотын банкны хэлтсийг 1979 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн контор болгон өөрчилж, эрх үүргийг нь өргөтгөжээ. Аймгийн банкны хэлтсийг контор болгон орлогч даргатай, 2-3 хэлтэстэй, нийт ажиллагсдыг захиргааны болон үйлчилгээ, хяналтын ажилтан гэж ангилан, үйлчилгээ хяналтын ажилтанг ажлын тооны нормативтай, цалин хөлсийг интервалтай болгосон юм. Орон нутаг дахь банкны контор нь өөрийн харьяанд зарим төв суурин, хотод салбар хэлтэс, сумдад тооцооны касс гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулах болжээ.

УЛСЫН БАНКНЫ 1-Р ХЭЛТЭС

1924 оны зун Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн банкны 1-р хэлтэс Алтанбулаг хотноо байгуулагджээ. Тус хотод байсан Хаант Оросын банкны салбар байрлаж байсан бат бэх тохилог байшинд албан хэргээ эхлүүлжээ.



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

МАТИГАР ИЛД

1948 оны 5 сарын 1-нээс Монгол улсын бүх дипломатуудад ёслолын дүрэмт хувцасны хамт матигар илдийг дагалдуулан олгосон байна.

АЛТ ШАРМАЛ ТОНОГТОЙ МАТИГАР ИЛД

Он: 1948

Жин: 466 гр, 44 х 3 см

1 х 1.5 см хэмжээтэй кабошон засалттай зууван бөөрөнхий хэлбэртэй бадмаараг чулуу

Эх загвар: Урлагийн гавьяат зүтгэлтэн Төрийн шагналт зураач Д.Чойдог

Онц бөгөөд бүрэн эрхт элчин, элчин сайд, зөвлөх, тэргүүн зэргийн нэгдүгээр нарийн бичгийн дарга, дэд элчин нарын хэрэглэх илд нь алт шармал тоногтой, хар ширэн бүрээс бүхий бариул, хуйтай байна. Бариулын тольт дээр бадмаараг шигтгээтэй бөгөөд хуйны алтан тоног дээр 1940 оны төрийн сүлдийг дүрсэлсэн.





МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2019.03.21)

Мөнгөний бодлогын хорооны шийдвэр танилцуулах Хэвлэлийн бага хурал 2019 оны гуравдугаар сарын 21-нд боллоо. Хурлын эхэнд Мөнгөний бодлогын хорооны гишүүн Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан мэдэгдлийг уншиж танилцуулан, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа Мөнгөний бодлогын шийдвэр гаргахад авч үзсэн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг сэтгүүлчдэд танилцуулсан юм. Үүний дараа сэтгүүлчид гишүүдээс сонирхсон асуултаа асууж, хариулт авлаа. Хэвлэлийн бага хурлын тэмдэглэлийг бүрэн эхээр нь хүргэе.

МБГ-ын захирал **Б.БАЯРДАВАА**: МБХ эдийн засаг бүрэн сэргэсэн гэж үзсэн

Мөнгөний бодлогын хорооны хурлын эхэнд гишүүд эдийн засгийн нөхцөл байдлыг илэрхийлэх зарим тоон мэдээллийг сонсож, “Эдийн засаг бүрэн сэргэсэн байна” гэж дүгнэсэн. Үүнийг илэрхийлэх хэд хэдэн индикаторыг энд дурдая.

1 дүгээрт: 2016 оны гурав, дөрөвдүгээр улиралд эдийн засгийн суурь болон ерөнхий инфляци буурч, дефляцид хүрч, агшиж байсан. Харин одоо бол энэ үзүүлэлт сэргэж, 7-8 хувийн өсөлтөд хүрч, сэргэсэн байна. Энэ нь эрэлт агшсан төлөвөөс эрэлт сэргэсэн төлөвт шилжсэнийг илтгэж байна.

2 дугаарт: Эдийн засгийн өсөлт 2016 оны эхний 3 улиралд өмнөх 4 улирлынхаа нийлбэрээр -1.4 хувиар агшиж байсан. Харин оны эхнээс гуравдугаар улирлынхаа дүнгээр -6.0 хувиар ашгиж байсан бол 2018 оны байдлаар жилийн дүнгээрээ 6.9 хувиар, дөрөвдүгээр улирлын байдлаар 8.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3 дугаарт: Эдийн засаг дахь ажилгүйдлийн түвшин 2016 оны нэгдүгээр улиралд 11.6 хувьд хүрч өсч байсан бол 2018 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 6.6 хувьд хүрч буурлаа.

4 дүгээрт: Өрхийн бодит орлого 2014-2016 оны хооронд 12 улирлын турш дараалан агшиж байсан бол 2017 оны нэгдүгээр улирлаас эхлэн сэргэж, 2018 оны дөрөвдүгээр улирал гэхэд 7.4 хувийн бодит өсөлттэй

байна.

5 дугаарт: Өрхийн нийт хэрэглээ 2016 оны 2-3 дугаар улиралд агшсан үзүүлэлттэй байсан. Харин 2018 оны дөрөвдүгээр улиралд 3.3 хувиар өссөн байна.

6 дугаарт: Хөрөнгө оруулалтын хэмжээ 2013-2015 оныг дуустал агшилттай байсан бол 2018 онд 27.2 хувиар өслөө.

7 дугаарт: Төлбөрийн тэнцлийн төлөв байдлыг авч үзвэл 2013-2016 онд нийтдээ 2.6 тэрбум ам.долларын алдагдалтай байсан бол 2017-2018 оны байдлаар 1.3 тэрбум ам.долларын ашигтай гараад байна. Үүн дээр Монголбанкны алт худалдан авалт, түүгээр дамжсан валютын нөөцийн нэмэгдлийг тооцвол 1.8 тэрбум ам.долларын ашигтай байгаа.

8 дугаарт: Үүний үр дүнд гадаад валютын нийт нөөц 2016 оны сүүлээр 1 тэрбум ам.доллар байсан бол 2019 оны хоёрдугаар сарын байдлаар 3.6 тэрбум ам.доллар болж нэмэгдээд байна.

9 дүгээрт: 2014-2016 оны туршид 2-3 удаа буураад байсан Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2018 онд зээлжих зэрэглэлийн томоохон гурван агентлаг сайжрууллаа.

10 дугаарт: Төсвийн тэнцэл 2011-2017 онд жилд дунджаар 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай байсан бол 2018 онд төсөв 11.9 тэрбум төгрөгийн ашигтай байв.

11 дүгээрт: Зээлийн жигнэсэн дундаж хүү 2016 онд 20 хувьтай байсан бол 2018 оны эцсийн байдлаар 16.9,

2019 оны хоёрдугаар сарын байдлаар 17.1 хувь болж, буураад байна.

12 дугаарт: Зээлийн өсөлтийн хувьд 2015-2016 оны туршид дунджаар 5 хувиар агшиж байсан бол 2018 онд 24 хувийн өсөлттэй байсан нь эдийн засаг руу зээл хөрөнгө оруулалтын эх үүсвэр болж гарсныг илтгэж байна.

2019 оны хувьд Монголбанк эдийн засгийн өсөлтийг 6.9 хувьд хүрнэ гэж үзэж байгаа. Өсөлтөд голлон нөлөөлж байгаа хүчин зүйл нь өрхийн хэрэглээ нэмэгдэх төлөвтэй байна. Мөн хөрөнгө оруулалтын өсөлт хэвийн түвшинд тогтворжиж, гадаад талдаа нүүрсний экспорт өсөхөөр байна. Уул уурхайн бус салбарын өсөлт мөн үргэлжилнэ. Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт хэвийн түвшиндээ үргэлжилж, банкны системээс зээл хөрөнгө оруулалтын эх үүсвэр болж эдийн засагт нийлүүлэгдэнэ. Гадаад эдийн засгийн төлөв байдлын хувьд БНХАУ-ын эдийн засаг 2019-2020 онд 6 орчим хувьтай байна. Харин Евро бүсийн эдийн засгийн өсөлт өмнөх хоёр жилийнхээс буурч 1.2 орчим хувьтай байх таамаглалыг дэвшүүлж байгаа. ОХУ-ын хувьд 2019 онд 1.5, 2020 онд 1.7 хувийн өсөлттэй байх бол АНУ-ын эдийн засгийн хувьд 2019 онд 2.5, 2020 онд 1.9 хувийн өсөлттэй байх төлөвтэй байна.

Экспортын барааны үнийн тухайд 2018 оны туршид нэлээд таатай жил байсан. Харин 2019 он гарсаар түүхий эдийн үнэ буурах төлөвтэй байгааг Монголбанк болон олон улсын байгууллагын шинжээчид мэдэгдэж байгаа. Нүүрсний үнийн хувьд харьцангуй өмнөх улиралд танилцуулж байсан төсөөллийнхөө орчимд авч үзсэн. Тухайлбал, 2019 оны дундаж үнэ 70 ам.доллар, 2020 онд 65 орчим ам.доллартай байхаар байна. Зэсийн үнэ 2019 оны туршид 6200 орчим ам.доллар, 2020 оны хувьд 6000 орчим ам.доллар байна гэж харж байгаа. Алтны төсөөллийг өмнөхөөс сайжруулсан. Тухайлбал, алтны үнийг унци тутамд нь 60-70 доллараар сайжруулсан. Түүхий нефтийн үнэ 2019 онд нэг тонн нь 65 орчим ам.доллар болж буурах төлөвтэй байна. Энэ нь Монгол Улсын дотоодын зах зээл дэх нефть бүтээгдэхүүнийн үнэд таатай нөлөө үзүүлэх болов уу. Төмрийн хүдийн үнэ мөн буурах төлөвтэй байна.

Төлбөрийн тэнцэл 2019 онд 500 орчим сая ам.долларын ашигтай гарах төлөвтэй байгаа бол инфляци 2019 оны гурав, дөрөвдүгээр улирлын дунджаар 7.6 орчим хувьтай байх төсөөлөл боловсрууллаа.

Инфляцийн төлөв байдалд нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйл томоохон нөлөө үзүүлж байгаа. Гэсэн хэдий ч Мөнгөний бодлогын хорооны хурлаар инфляци энэ онд төв банкны зорилтот түвшний орчимд, тогтвортой хадгалагдана гэж үзсэн.

БЛҮҮМБЭРГ ТВ:

Хэрэглээний зээлийг хумих бодлогын үр дүнд зээлийн эрэлт бичил санхүүгийн зах зээл рүү шилжих эрсдэлийг хэрхэн харж байна вэ. Банк бус санхүүгийн байгууллагуудад зээлийн эрэлт нэмэгдэж эхэлсэн гэх мэдээлэл байна. Энэ талаар ямар байр суурьтай байна вэ?

МБГ-ын захирал Б.БАЯРДАВАА:

Монголбанкны зүгээс хэрэглээний зээлийн талаар баримталж буй бодлогын үндсэн зорилго нь дунд, урт хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн системд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зорилготой. Энэ агуулгын хүрээнд шийдвэрүүд гарсан. Бодлогын шийдвэрүүд зах зээлд хэр зэрэг үр дүнтэй ажиллаж байна вэ гэдэг нь эхний хоёр сарын байдлаар тодорхой харагдаж эхэлсэн. Тодруулбал, хэрэглээний зээлийн жилийн өсөлт өнгөрсөн оны эцсийн байдлаар 55 хувьд хүрч байсан бол 2019 он гарсаар эхний хоёр сарын байдлаар жилийн дүнгээрээ 42 орчим хувьд хүрч, өсөлтийн хурд саарч байна. Банкны бус санхүүгийн секторын хувьд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад байдаг. Энэ утгаараа Монголбанк энэхүү бодлогын шийдвэрийг шууд банк бус, санхүүгийн салбарт мөрдүүлэх боломжгүй. Санхүүгийн зохицуулах хороотой хамтраад ажлын хэсэг гаргаад, зээлийн төлөвийн судалгааг хийж байна. Банкны бус санхүүгийн секторын 2019 оны нэгдүгээр улирлын зээлийн тайлан одоогоор гараагүй байна. Нэгдүгээр улирлын тайлан гарсны дараа дүр зураг нэлээд тодорхой болно. Нөгөө талаас банкны бус санхүүгийн секторын санхүүгийн зуучлалын хурд, үр ашиг нэлээд сайжирсан дүр зураг бий. Банкны бус санхүүгийн секторын зээл нэлээд хурдтай шийдвэрлэгдэж байгаа нь тус салбар жижиг зээлүүдэд банкны салбартай өрсөлдөх давуу талыг бий болгож байна. Энэ нь ч зээлийн өсөлтөд нөлөөлж байгаа болов уу гэж харж байгаа.

МҮОНТ:

Монголбанк эдийн засгийн төлөв байдлын талаарх таамаглалуудаа шинэчилсэн байна. Зээлжих

зэрэглэлийн “Фитч” агентлагаас саяхан гаргасан тайландаа Монгол Улсад ойрын хэдэн сарын хугацаанд улс төрийн бодлогын тогтворгүй байдлын эрсдэл улам нэмэгдэх магадлалтай байна гэж дурдсан байна. Энэ эрсдэлийг Монголбанк таамаглалдаа хэрхэн авч үзсэн бэ?

МБГ-ын захирал Б.БАЯРДАВАА:

Улс төрийн тогтвортой байдлын тухайд яг ийм эрсдэл үүснэ гэж хэлэхэд хүндрэлтэй. Гадны шинжээчид асуудлыг ямархуу байдлаар харж, дүгнэлт гаргасныг би хараагүй учраас тодорхой хэлэх боломжгүй байна. Гэхдээ эдийн засгийн ерөнхий төлөв байдал, гадаадын хөрөнгө оруулагчдын хандлага, Монгол Улсын Засгийн газрын гадаад зах зээл дээрх бондуудын өгөөж, хүүний түвшин тогтвортой байна. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчид Монголын одоогийн эдийн засгийн нөхцөл байдлыг тийм ч сөргөөр хүлээж авахгүй байгааг илтгэж байгаа болов уу. Нөгөө талаас оны эхэнд Монголын ипотекийн корпораци гадаад зах зээлд 250 сая ам.долларын бонд амжилттай арилжаалсан. 2018 оны эцэст Монгол Улсын Хөгжлийн банк мөн гадаад зах зээл дээр амжилттай бонд гаргасан. Энэ байдлаас харвал хөрөнгө оруулагчидтай харилцаа сайн байна гэж харагдаж байна. Удахгүй зээлжих зэрэглэлийн байгууллагууд Монгол Улсад айлчилж, уулзалт, хэлэлцээрүүд хийгдэнэ. Тэр үед нэлээд тодорхой яриа, хэлэлцээрүүд явагдах болов уу.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН:

Төлбөрийн тэнцэл 500 сая ам.долларын ашигтай гарна гэсэн төсөөлөл хийсэн байна. Үүнд яг ямар эерэг хүчин зүйлүүд нөлөөлөх вэ?

Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.ГАН-ОЧИР:

Монголбанкнаас гаргасан төсөөллөөр төлбөрийн тэнцэл 500 орчим сая ам.долларын ашигтай гарахаар байна. Үүнд хэд хэдэн хүчин зүйлсийг авч үзлээ. Эхний ээлжинд нүүрсний экспорт өмнөх оноос 10 гаруй хувиар өсч, 39 сая орчим тонн хүрнэ гэж үзэж байгаа. Нүүрсний үнэ ч бас оны эхнээс өсөлттэй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсөөд байна. Тийм учраас нүүрсний экспортын биет хэмжээ болон үнийн тухайд ямар нэгэн сөрөг өөрчлөлт гарахгүй, эерэг байх дүр зураг харагдаж байна. Импорт өсөх хандлагатай ч өсөлт нь өмнөх оноос нэлээд буурах болов уу гэж хүлээж байгаа. Учир нь нийт зээлийн өсөлт саарснаар түүний импортыг өдөөх дарамт суларна гэж хүлээж

байна. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны тэнцэл дээр өмнөх онд гарсан эерэг үр дүн энэ онд үргэлжилнэ. Төлбөрийн тэнцэл бүхэлдээ ашигтай гарахад гадаадын шууд хөрөнгө оруулалт томоохон эерэг нөлөө үзүүлэхээр байна. Жишээ нь бид бүхэн энэ онд Монгол Улсад 1.6 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэхээр тооцоололдоо авч үзлээ. Түүнээс гадна Монголын хувийн хэвшлүүд гадаад зах зээлээс эх үүсвэр оруулж ирсэн. Одоогоор 300 орчим сая ам.доллар оруулж ирсэн нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлөхөөр байна. Эцэст нь Монгол Улс ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд энэ онд хуваарийн дагуу орж ирэх ёстой санхүүжилтүүд бий. Мөн өнгөрсөн онд орж ирэх байсан ч хойшлогдсон, энэ онд орж ирэхээр хүлээгдэж буй санхүүжилтүүд ч байна. Энэ бүгдийг харгалзан үзээд, 2019 онд төлбөрийн тэнцэл эерэг үр дүнтэй гарах боломжтой гэдэг урьдчилсан тооцооллыг гаргаад байна.

25 ТВ:

Монголбанк аж ахуйн нэгжид 160 тэрбум төгрөгийн зээл олгосон гэдэг асуудал яригдаж байгаа. Монголбанк үнэхээр хууль зөрчөөд, аж ахуйн нэгжид зээл олгосон асуудал байгаа юу?

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН:

160 тэрбум төгрөг гэдэг нь Улаанбаатар хотын банктai холбоотой асуудал юм. 2012-2016 онд төсвийн шинжтэй арга хэмжээ, хөтөлбөр хэрэгжүүлж байх үед олгогдсон зээл юм. Энэхүү зээлийн гэрээг цуцлаад, эргэж төлүүлэх тал дээр Монголбанкнаас ажлын хэсэг гарч ажиллаж байна. Саяхан, шинээр олгосон зээл биш.


25ТВ:

Банкууд сүүлийн үед дэргэдээ өөр компани байгуулаад, аж ахуйн үйл ажиллагаа эрхлээд байна гэх мэдээлэл байна. Хуулиараа банкууд ийм үйл ажиллагаа явуулах боломжтой юм уу?

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН:


Банкууд дэргэдээ охин компанитай байж, өөр салбарын бизнес эрхлэх асуудлыг бид бүхэн өнгөрсөн онд батлагдсан хуулийн өөрчлөлтөөр бүрэн шийдвэрлэсэн. Энэ хүрээнд банк доороо охин компанитай байж болохгүй. Тийм хуулийн зохицуулалттай болсон байгаа.

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



- **M2** мөнгөний жилийн өсөлт **23.1%** -д хүрч **19.6** их наяд ₮-т хүрэв.
- Өмнөх сараас **0.3%**-иар буюу **60** тэрбум ₮-өөр буурав.
- Үүнээс **M1** мөнгө **6%** (219.8 тэрбум ₮) –иар буурч, **бусад хадгаламж 1%** (159.8 тэрбум ₮) –иар өссөн байна.
 - **M1** → ₮-ийн харилцах **102.2** тэрбум ₮-өөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө **117.5** тэрбум ₮-өөр өсөв.
 - **Бусад хадгаламж** → \$-ийн хадгаламж **92** тэрбум ₮-өөр өсч, \$-ийн харилцах **49** тэрбум ₮-өөр, ₮-ийн хадгаламж **18.9** тэрбум ₮-өөр буурав.

Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮




Зураг 1.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц




- Нийт **M2** мөнгөний нийлүүлэлтийн **52.1%**-ийг ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол **15.5%**-ийг валютын хадгаламж, **14.7%**-ийг ₮-ийн харилцах, **14.7%**-ийг валютын харилцах, үлдсэн **2.9%**-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ **13.2** их наяд ₮-т хүрснээс **84.3%**-ийг иргэдийн хадгаламж, **15.7%**-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн **80.1%**-ийг, байгууллагын хадгаламжийн **60.5%**-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байна.


Зураг 1.4. Нийт хадгаламж



Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Нийт зээл



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **25%**-иар өсч **17.1** их наяд ₮-т,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл **32%**-иар өсч **9.0** их наяд ₮-т,
- Хувийн байгууллагынх **16%**-иар өсч **7.9** их наяд ₮-т тус тус хүрчээ.
- Нийт зээлийн **85%**-ийг, Иргэдийн зээлийн **98%**-ийг, хувийн байгууллагын зээлийн **69%**-ийг ₮-ийн зээл бүрдүүлж байна.

Зураг 2.3. Зээл, зээлийн чанар



- Нийт зээл 17.1 их наяд ₮ (Төгрөгийн зээл 14.5 их наяд ₮, Валютын зээл 2.6 их наяд ₮)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас 28 тэрбум ₮ буюу 0.2%-иар өссөн.
- Хэвийн зээл өмнөх сараас 120 тэрбум ₮ буюу 0.8%-иар буурсан.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 92 тэрбум ₮ буюу 11%-иар өссөн.
- Чанаргүй зээл өмнөх сараас 56 тэрбум ₮ буюу 3%-иар өссөн байна.

Зураг 2.4. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



Зураг 2.5. Хугацаа хэтэрсэн зээл (салбар бүтэц)



- Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 79%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 2.6. Чанаргүй зээл (салбарын бүтэц)



- Нийт чанаргүй зээлийн 85%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.



МӨНГӨ,
САНХҮҮГИЙН
СТАТИСТИК


ИПОТЕКИЙН
ЗЭЭЛ

ГАДААД
СЕКТОРЫН
СТАТИСТИК

Төлбөрийн тэнцэл

Гадаад сектор

4.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны 1 дүгээр сар





СУДЛААЧИД МОНГОЛ УЛСЫН

ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГЫН ТУХАЙ

Л.АРИУНАА

Удирдлагын Академийн Эдийн засаг, санхүүгийн тэнхимийн эрхлэгч,
Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн доктор, дэд профессор

Удирдлагын Академийн Эдийн засаг санхүүгийн тэнхимийн үе үеийн эрдэмтэн багш нар хамтран “Монгол төрийн эдийн засгийн бодлого: сорилт, сурамж, асуудал 1911-2018” номоо уншигчдынхаа гарт хүргүүлээд байна. Энэхүү номоо бүтээх анхны санаа 2017 оны 12 сард болсон Эдийн засаг санхүүгийн тэнхим байгуулагдсаны 70 жилд зориулан зохион байгуулсан онол арга зүйн нээлттэй семинар, уулзалтуудын үеэр эрдэмтэн, багш нараас маань гарч, энэ талаар эдийн засгийн ухааны сургалт, судалгааны түүхэн хөгжил, өөрчлөлт шинэчлэлт, цаашдын чиг хандлагын санал бодлоо хуваалцсанаар тэнхимийнхээ 70 жилд зориулан хамтран хамтран бүтээхээр болсон юм. “Монголбанкны мэдээлэл” товхимлын эрхэм уншигч танд Монголын эдийн засгийн хөгжлийн түүхийг тэмдэглэсэн энэхүү судалгааныхаа бүтээлийг танилцуулах болсондоо талархаж байна.

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, ард иргэдийн чинээлэг байдал нь төрөөс хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлоготой шууд холбоотой байдаг. Харин эдийн засгийн бодлогыг удирдах зохицуулалтын төв нь тухайн орны эдийн засгийн тогтолцоо юм. Эдийн засгийн тогтолцоо нь улс орны нийгмийн тогтолцооны нэг хэсэг бөгөөд ард иргэдийн хамтын амьдралыг зохицуулдаг. Зарчмын хувьд зах зээлийн болон төрийн гэсэн хоёр төрлийн зохицуулалтын механизм байх ба төрийн бодлогын үүрэг бол зах зээлийн механизм

зохистой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Тиймээс эдийн засгийн бодлогыг үр дүнтэй зохион байгуулахад үндсэн хууль, ердийн хуулиуд, хуульчлагдсан эрх зүйн баримт бичиг, түүнчлэн бичигдээгүй хэм хэмжээнүүд нь чухал ач холбогдолтой. Эдийн засгийн ухааны эрдэмтэн судлаачид дэлхийн өндөр хөгжсөн орнууд болон богино хугацаанд эрчимтэй хөгжсөн Азийн бар орнуудын эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч

хүч бол өөрийн орны онцлог нөхцөлийг тусгасан Зөв бодлогыг Сайн хэрэгжүүлсэний үр дүн гэж үздэг билээ. Тиймээс бид энэхүү номондоо 1911 оноос өнөөг хүртэл Монгол Улсын төрөөс хэрэгжүүлж ирсэн эдийн засгийн бодлогын зорилго, арга хэрэгсэл, үр нөлөөнд дүн шинжилгээ хийснээр бодлогын түүхэн сургамж, сорилтууд болон өнөөгийн тулгамдсан асуудлын талаарх дүгнэлтийг толилуулж байгаа юм.

Биднийг номоо бичиж эхлэх үед манай улсын эдийн засаг хямралтай байлаа. Монгол Улсын Засгийн газар хямралыг даван туулахын тулд 2017 онд ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт” хамрагдаж 434.3 сая ам.долларын зээл авсан нөхцөл байдалтай байв. Эдийн засгийн бодлогын анхдагч зорилгын хувьд үйл явцын бодлого, бүтцийн болон дэг журмын бодлого хэмээн гурав ангилсан байдаг. Бид ч номоо бичихдээ үүнд үндэслэн агуулгаа дөрвөн бүлэг авч үзсэн юм. Бүлэг тус бүрт эрдэмтэн судлаачдын дүн

шинжилгээ бүхий өгүүлүүд бий.

Нэгдүгээр бүлэг: Богд Хаант Монгол Улс, төвлөрсөн төлөвлөгөөт Бүгд Найрамдах Монгол Ард Улс болон зах зээлийн тогтолцоонд шилжих эхэн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, бодлого, үйл ажиллагаа, үр дүн болон сорилт, сургамж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлон бичив. Тухайлбал, Богд хаант улсын үед Монгол Улс нүүдлийн тархай бутархай, амиа аргацаасан мал аж ахуй ноёлсон, үндэсний үйлдвэрлэл бараг хөгжөөгүй эдийн засгийн хувьд хараат, хоцрогдсон орон байсан бөгөөд

эдийн засгийн хувьд бие даах чадамжгүй байсны улмаас хүчирхэг гүрнүүдийн бүтээгдэхүүнийг борлуулах зах зээл, мал, түүнээс гаралтай түүхий эдийг ханган нийлүүлэх талбар байжээ. Хэдий тийм ч Богд хаант Монгол Улсын төрийн эдийн засгийн бодлого нь улс орныхоо язгуур эрх ашгийг дээдлэн эдийн засгийг сэргээн төвхнүүлэх, ялангуяа мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих, байгалийн нөөц баялгийг улсын мэдэлд авч түүний хяналт, ашиглалтыг сайжруулах, аж ахуйн шинэ хэлбэр, таваар мөнгөний харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Тэгвэл БНМАУ байгуулагдаж, “Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг: ардын аж ахуйтныг хөгжүүлсэн нь” сэдэвт дэд бүлгийг бичиж боловсруулсан бөгөөд энэ үед манай оронд он цагийн ороо бусгаа байдал, баруунтан,

зүүнтний алдаа завхрал, улс төрийн их хэлмэгдүүлэлт, дэлхийн болон орон нутгийн чанартай дайн байлдаан зэрэг хүнд бэрх сорилтууд тулгарч байсан ч улс, ардын аж ахуйн уламжлалт хийгээд орчин цагийн шинэ салбаруудыг үүсгэн байгуулахын төлөө тухайн үеийн төр засгаас авч хэрэгжүүлсэн олон талт бодлого, үйл ажиллагаа нь өнөөгийн Монгол Улсын тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэх, түүнийг хөгжлийн шинэ үе шатанд дэвшин ороход нэн чухал үүрэг гүйцэтгэж ирснийг тоймлон харуулсан байна. Мөн энэ бүлэгт БНМАУ-ын үйлдвэржүүлэлт, хөдөө аж ахуйн хоршооллын үйл явцыг тухайн үеийн түүхэн баримтууд, нам засгийн дэвшүүлж байсан төрийн

бодлого, асуудлуудыг авч үзсэн бөгөөд энэ үед Монгол орны нийгмийн байгуулал солигдож, түүхэн шинэ нөхцөлд нийгмийг хөгжүүлэх, зорилтуудыг шийдвэрлэх тулгуур хүчин зүйл болсон үйлдвэр, хөдөө аж ахуйн асуудлуудыг авч үзсэнээс гадна тухайн үед эх орны дайн, гадаад дотоодын зөрчил тэмцэл, хамгийн хүнд бэрх, шалгуурыг сорьсон цаг үе байсан хэмээн тодорхойлжээ. Манай улсын эдийн засгийн түүхэн хөгжлийн явцын дараагийн үе бол мэдээж хэрэг чөлөөт, ардчилсан зах зээлийн зарчимд шилжсэн явдал байв. Энэ тухай өгүүлэхдээ “Зах зээлд шилжих эхэн үеийн эдийн засгийн байдал” сэдэвт дэд бүлэгт социалист төвлөрсөн төлөвлөлтийн гол онцлог, үндсэн зарчим болон төвлөрүүлэн төлөвлөхөд тулгарах мэдээлэл, зохицуулалт, инновац, үр ашгийн асуудлууд болон системийн шилжилт хэмээх өөрчлөн байгуулалтын стратегийн онол арга зүйд тулгуурлан Монгол Улсын шилжилтийн үеийн нөхцөл байдал, өөрчлөлт шинэчлэлийн

хэрэгжилтийг авч үзсэн бөгөөд 1990 онд эхэлсэн зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явц бүрэн дуусаагүй хэмээн дүгнэжээ.

Хоёрдугаар бүлэг: Эдийн засгийн үйл явцыг зохицуулах, ялангуяа эдийн засгийн конъюнктурын өөрчлөлтөнд нөлөөлөх зорилго бүхий мөнгөний болон төсөв-санхүүгийн тогтворжуулах бодлого, орлого эд хөрөнгийн дахин хуваарилалтыг зохицуулах татварын бодлого, төсвийн зарлагын бодлого, санхүүгийн зах зээлийн бодлого, улсын өрийн удирдлага болон төрийн санхүүгийн хяналт хариуцлагын асуудлуудыг багтаав. 1911 оноос өнөөг хүртэлх Монгол Улсын төсөв санхүүгийн нөхцөл байдал, мөн эдийн засгийг тогтворжуулах төсвийн бодлогын онол, үзэл баримтлалд тулгуурлан Монгол Улсын төсвийн бодлогод дүн шинжилгээ хийж тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон юм. 1990-2018 онд манай засгийн газрын нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ нэлээд тогтворгүй хандлагатай байгаа нь манай улсын хувьд засгийн газрын эдийн засагт гүйцэтгэх үүрэг тодорхой бус байгааг илтгэнэ. Монгол Улсын төсөв-санхүүгийн бодлого нь эдийн засгийн мөчлөг дагасан байдлаар тогтсон дүрэмгүй хэрэгжиж ирсэн бөгөөд ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдах замаар макро эдийн засгийн тогтворжилтийг хангаж ирсэн билээ.

Тэгвэл мөнгөний бодлогын хувьд XX зууны эхэн үеийн Монгол орны эдийн засгийн байдал, мөнгө-зээлийн бодлого хэрэгжүүлэх суурь дэд бүтцийн хөгжил, төвлөрсөн



төлөвлөгөөт

эдийн засгийн тогтолцооны мөнгө-зээлийн бодлогод баримталсан зарчим, мөнгө-зээлийн бодлогоор хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлсэн стратеги, шилжилтийн үеийн банкны салбар, 1990 оноос хойших Монголбанкны бодлого үйл ажиллагааны тухай тэмдэглэлээ. Ерөнхийдөө Монголбанк шилжилтийн эхэн үед үнийн өсөлтийг саармагжуулах, төгрөгийн худалдан авах чадварын уналтыг хязгаарлах, мөнгөний нийлүүлэлтийг багасгахад чиглэсэн харьцангуй хатуу мөнгөний бодлого явуулсан бол сүүлийн жилд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, Монголбанк санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэглэхээр тусгасан юм.

Төсөв, мөнгөний бодлогоос гадна татварын бодлого манай улсад ямар байсан, ямар байгаа тухай авч үзэхдээ 1991 оноос хойш олон улсын нийтлэг жишигт нийцсэн татварын тогтолцоог бий болгон

улмаар улс, орон нутгийн төсвийг орлогын тогтвортой эх үүсвэрээр хангах, дотоодын үйлдвэрлэл болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, орчин үеийн татварын албыг бүрдүүлэх бодлогыг дэс дараатай хэрэгжүүлж, 1993 онд “Татварын багц хууль” нэртэй 5 хууль баталсан. Ер нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд орсноос хойш батлагдсан хуулиудаас хамгийн олон өөрчлөлт орсон нь татварын хууль болох талаар тусгажээ.

Энд бас өрийн удирдлагын талаар тэмдэглэхгүй өнгөрч болохгүй юм. Манай орны нийт гадаад өрийн хэмжээ 27.9 тэрбум ам.доллар болж, 2017 оны ДНБ-ээс 2.6 дахин их байгаа нь өрийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангахуйц зохистой түвшнээс давсан төдийгүй, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгосныг дурдаад үүнтэй уялдуулан “Их өр”, үүссэн түүх, бүтээн байгуулалт, төлбөрийн талаар тодорхой судалсан юм. “Их өр”-ийг зохицуулан 98 орчим хувийг нь чөлөөлүүлж, үлдсэн хэсгийг нь өөрийн эх үүсвэрээр шийдвэрлэсэн нь Монгол Улс эдийн засгийн бие даасан байдлаа бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн талаар хүлээн авч уншаарай.

Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжиж санхүүгийн зах зээл нэг тулгууртаас олон тулгуурт болох хөгжлийнхөө алхамыг тавьсан нь Үнэт цаасны зах зээл байв. Үүсээд 30 жил болсон боловч эдийн засагт мэдэхүйц үүрэг гүйцэтгэж чадахгүй, санхүүгийн салбарт зөвхөн арилжааны банк дангаар ноёрхож, урт хугацаат эх үүсвэрийн олдоц муу, өртөг өндөр байгаагаас шалтгаалан бодит салбарт үйл

ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хөгжлийг санхүүжүүлэх боломжгүйд хүрч олноор дампуурах, ажиллаж байгаа хэсэг нь арай ядан амь залгуулах түвшнээс хэтэрч чадахгүй байгааг онцолсон болно.

Гуравдугаар бүлэг: Эдийн засгийн бүтэц болон бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг төлөвшүүлэн хөгжүүлэх зорилго бүхий эдийн засгийн хөгжлийн, гадаадын шууд хөрөнгө оруулалтын, эрчим хүчний, хөдөө аж ахуйн бодлого, аялал жуулчлалын болон боловсролын бодлого зэргийг судалснаа өгүүлэв. Манай улсад урт болон дунд хугацааны үндэсний болон салбарын бодлогууд олон байгаа ч хэрэгжилт хангалтгүй, салбарын бодлогын баримт бичгүүдтэйгээ уялдаагүй, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжих хугацаа тодорхойгүй, бодлогын зорилго, зорилт давхацсан, хоорондын уялдаа сул, институци болон мэргэшсэн хүний нөөцийн залгамж чанар дутагдалтай зэрэг асуудлаас үүдэн бодлогын хэрэгжилт хангалтгүй. Мөн салбарын хүрээний мастер төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөл зэрэг бодлогын баримт бичгүүд нь урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой уялдаагүй, цаг хугацааны хувьд харилцан хамааралгүй зэрэг дутагдалтай байгаа юм.

Дөрөвдүгээр бүлэг: Эдийн засгийн дэг журмыг төлөвшүүлэн тогтоох, ерөнхий нөхцөлийг төлөвшүүлэх өрсөлдөөний бодлого, хүрээлэн буй орчны бодлого болон өмчлөх эрхийн асуудлуудыг судлан толилуулав. Монгол Улсын өрсөлдөөний бодлогын өнөөгийн байдал, өрсөлдөөний хууль,

хамааралтай бусад хууль тогтоомж, Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын шийдвэр болон зах зээлийн судалгааны талаар судалж, Монгол Улсад өрсөлдөөний хууль хэрэгжээд удаагүй бөгөөд төрийн бодлогын хувьд харьцангуй туршлага багатай салбар болохыг онцлон жижиг эдийн засагтай улсын хувьд өрсөлдөөний зохицуулалтын онцлог, өрсөлдөөнийг төрөөс зохицуулж буй байгууллагуудын үйл ажиллагаа, салбарын онцлог зэргийн талаар тодорхойлон дүгнэсэн юм.

Тус бүлгээс уншигч танд өмчийн тухай ойлголт, хувийн өмчид холдбогдох эрх зүйн зохиццуулалт, тулгамдаж буй асуудлуудыг судалсан тухай унших юм. Зах зээлийн тогтолцоонд өмчлөх эрхийн үндсэн асуудал, өмчлөх эрхийг баталгаажуулах эрх зүйн орчин, өмчийн хэлбэр зэргийг судалсан. Өмч түүний дотор хувийн өмч эзэмших явдал нь хүний эрхийг дээдэлсэн чөлөөт нийгмийн амин чухал эд, эс юм. Гэтэл хувийн өмчид шууд болон шууд бусаар халдсан үйлдэл гаргадаг субъект нь нэг иргэн, байгууллага төдийгүй төр байгаа нь эдийн засгийн харилцааны шударга ёс алдагдах, иргэний нийгмийн суурь зарчмууд алдагдах, хүний эрх ноцтой зөрчих анхдагч нөхцөл болсоор байна гэж дүгнэжээ. Эцэст нь хэлэхэд эдийн засгийн шинжлэх ухааны онол арга зүйд тулгуурлан Монгол Улсын эдийн засгийн байдал, эдийн засгийн бодлогын талаар судалж бичсэн энэхүү бүтээл маань манай орны түүхийн чухал үеүүдийн нөхцөл байдлыг тодорхойлон гаргаж, тэдгээр өөрчлөлт шинэчлэлийн онцлогийг танин мэдэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.



Х.БАТЧУЛУУН: ТОДОРХОЙ 9 ЧИГЛЭЛЭЭР ҮНЭЛГЭЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ГЭЖ ҮЗЭЖ БАЙГАА

Энэ удаа бид манай улсын гадаад гүйлгээнд учирч буй саад бэрхшээлийг хэрхэн даван туулах боломжтой эсэх талаар Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга Х.Батчулууныг Банкир буландаа урьсан юм. Түүнтэй үүсээд буй бэрхшээлийн шалтгаан, шийдвэрлэх арга замын талаар ярилцсан юм.

Санхүүгийн мэдээллийн алба гэхээр хүмүүс нэг их сайн мэдэдгүй. Тэгэхээр Санхүүгийн мэдээллийн алба яг юу хийдэг тухай тайлбарлаж өгөөч?

Санхүүгийн мэдээллийн алба анх 2006 онд Монголбанкны дэргэд байгуулагдсан. Санхүүгийн мэдээллийн алба үйл ажиллагаагаараа төв банктai нягт холбоотой боловч шууд харьяалагддаггүй бие даасан байгууллага юм. Дэлхийн улс орнуудын санхүүгийн тагнуулын байгууллагууд ихэндээ энэ жишгээр байгуулагдсан байдаг. Санхүүгийн мэдээллийн алба Мөнгө угаах болон терроризмыг сахуужуулэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Санхүүгийн мэдээллийн албаны даргыг Монголбанкны Ерөнхийлөгч томилдоггүй байх нь?

Санхүүгийн мэдээллийн албаны даргыг хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгч хууль сахиулах холбогдох байгууллагын даргатай зөвшилцөж, томилдог.

2006 онд байгуулагдсан юм байна. Ерөнхийдөө мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагын дагуу дэлхий дахинд гарч ирж байгаа бүтэц гэж ойлгож байгаа. Манайх ч бас энэ жишгээр явж, тодорхой гэрээнд гарын үсэг зурсан юм уу?

Монгол Улс санхүүгийн мэдээллийн албыг байгуулсны хувьд “Эгмонт” бүлгийн гишүүн.

“Эгмонт” бүлэг нь дэлхийн улс орны санхүүгийн мэдээллийн албадын бүлэг юм. Түүнээс гадна Монгол Улс өөрөө мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази, Номхон далайн бүсийн бүлгийн гишүүн. Энэ нь ФАТФ-ын төрлийн байгууллага бөгөөд ФАТФ-аас гарч байгаа бүх зөвлөмжүүдийг Ази, Номхон далайн бүсийн бүлгийн гишүүн улсуудад хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй байгууллага юм.

Энэ байгууллага өнөөдрийн Монголын амьдралтай яаж холбогдож байна вэ гэхээр сүүлийн үед манай зарим банкны гадаад гүйлгээ Америкийн банкуудын энд тэнд гацаж байна. Энэ ямар учиртай вэ?

Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрээ хэр зэрэг үйл ажиллагаа явуулж байна вэ? Тогтолцоо байна уу? Байлаа гэхэд үр дүнгийн хувьд хэр зэрэг чанартай ажиллаж байна вэ гэдгийг тогтоох харилцан үнэлгээг 2016-2017 онд Ази, Номхон далайн бүсийн бүлгээс хийсэн. Харамсалтай нь Монгол Улс энэ үнэлгээгээр тааруухан дүн авсан. Аливаа улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдал дээр тааруухан дүн авбал, бусад орнууд өөрийнхөө санхүүгийн секторыг хамгаалах зорилгоор тухайн улстай холбоотой мөнгөн урсгалд хяналтаа чангалж, бидний ярьдгаар “харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа”-г илүү нягт хийж эхэлдэг.

2017 онд хийсэн харилцан үнэлгээний тайлангаар яагаад муу дүн авчихав аа?

Түүхийг яривал 2017 оны харилцан үнэлгээ бол манай түүхэнд хоёр дахь нь юм. Анхны харилцан үнэлгээний тайлан 2007 онд гарсан байдаг.

Харилцан үнэлгээ гэв үү?

Тийм. Харилцан үнэлгээний тайлан. Яагаад харилцан үнэлгээ вэ гэхээр Ази, Номхон далайн бүсийн бүлэгт багтдаг улс орнууд бүлгийн гишүүн орны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог харилцан шалгаж, үнэлгээг гаргадаг юм. Жишээ нь манай Ази, Номхон далайн бүсийн бүлэгт Австрали, Америк, Хятад зэрэг олон улс ордог. Монголыг үнэлэх багт Хятад, Австралийн мэргэжилтнүүд байсан. Монголын төлөөлөл Японыг үнэлэх

харилцан үнэлгээний багт ажиллаж байсан түүхтэй.

Эргээд асуултаа орьё. Монгол Улс яагаад тааруухан дүн авчихав аа?

2017 онд манай улс ялангуяа терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр тааруухан үр дүн авсан. Мөн үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо Монгол Улсад байхгүй байна гэж дүгнэсэн байгаа. Санхүүгийн салбараа авч үзвэл банкны сектор харьцангуй гайгүй. Харин банк бус санхүүгийн сектор буюу Санхүүгийн зохицуулах хорооны хяналтанд байдаг байгууллагууд нэлээд муу үнэлгээ авсан.

Яагаад муу үнэлгээ авчихав?

Яагаад гэвэл Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013 онд шинэчлэн батлагдсан боловч хэрэгжүүлэлтийг хангаж чадаагүй учир тааруухан гэж дүгнэсэн байгаа.

Хэрэгжүүлэхэд юу нь болохгүй байсан юм бэ?

Жишээ нь хяналт, шалгалтаа хийж чадахгүй байна. Банк бус санхүүгийн байгууллагууд буюу мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нь өөрийнхөө харилцагчийн тухай мэдээллийг цуглуулж чадахгүй байна. Харилцагчаа таних үйл ажиллагааг хийж чадахгүй байна. Хууль сахиулах байгууллагууд мөнгө угаах гэмт хэргийн талаар ойлголт сул, шүүхийн байгууллагууд энэ төрлийн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар туршлага хомс, шийдвэрлэсэн хэрэг байхгүй гэсэн дүгнэлтүүд гарсан.

Ойлгомжтой болгохын тулд

энгийн хэлээр ярья. Монгол Улсын банк бус санхүүгийн салбар маш хүчтэй өсч, хөгжиж байгаа. Тэгэхээр тэдгээр байгууллагууд харилцагчаа хаанаас ямар мөнгө авчирч хадгалуулаад, шилжүүлээд байгааг мэдэхгүй байна гэсэн үг үү?

Жишээ нь та бид хоёр банк эсвэл банк бус санхүүгийн байгууллага дээр очоод, мөнгө шилжүүлбэ. Тэгэхэд бид хоёр тухайн байгууллагын харилцагч байвал энэ хүн тогтмол мөнгө шилжүүлдэг, эсвэл хааяа шилжүүлдэг. Эсвэл шилжүүлж байгаа мөнгө нь тухайн хүний дансны дундаж мөнгөн урсгалтай таарч байна уу, үгүй юу гэдгийг нь мэдэх ёстой юм. Жишээ нь төрийн байгууллагад ажилладаг миний хувьд сарын эхэн болон сүүлчээр цалин орно. Тэр хоёрын хооронд зардал гарч байгаа учраас дансны үлдэгдэл доошоо буурч явна шүү дээ. Энэ мэтийн тухай харилцагчийн мөнгөний урсгалын ерөнхий дүр зургийг санхүүгийн байгууллага мэддэг байх ёстой. Харамсалтай нь энэ тал дээр манайхан хангалтгүй ажилладаг.

Тэгэхээр та жишээ нь сарын 1000 долларын орлоготой, жилд 12000 доллар олдог байлаа гэхэд нэг өдөр хүрч ирээд, 100 мянган ам.доллар шилжүүбэ гэвэл анхаарал татах нь байна?

Яг тийм.

Тэгэнгүүт асуух ёстой байх нь, хэн асуух ёстой вэ?

Тухайн санхүүгийн байгууллага.

Энэ мөнгө хаанаас орж ирсэн бэ? гээд үү?

Таны ерөнхий санхүүгийн байдалтай чинь энэ мөнгө таарахгүй

байна. Хаанаас, яагаад энэ өндөр дүнтэй мөнгө орж ирэв гэдгийг асуух ёстой.

Тэгээд асуухаар тухайн хүн хариулах ёстой?

Тийм. Хариулах, мэдээллээ өгөх үүрэгтэй.

Яагаад?

Иргэн хүний хувьд мэдээллээ өгөх үүрэгтэй.

Гэхдээ хэдэн төгрөг хаанаас өгсөн, авсан бэ гэдэг чинь тухайн хүний хувийн асуудал биш үү. Казино тоглосон байж болно шүү дээ?

Тийм. Казино тоглоод хожсон бол баримтаа л үзүүлэх ёстой юм. Казинод орохдоо 100 доллартай орсон, гарахдаа 100 мянган доллартай болсон гэдэг баримт нь л байж байх ёстой юм. Тэгээд асуудалгүй. Харин казино өөрөө мөнгө угаах гэмт хэрэг үйлддэг өндөр эрсдэл бүхий газар гэдгийг хүн болгон мэддэг байх хэрэгтэй.

Тэгэхээр энэ асуудал яагаад чухал болж байна вэ гэхээр аливаа улс ямар нэгэн байдлаар террорист үйл ажиллагаа явуулахыг санхүүжүүлэхээс сэрэмжлэх шаардлагатай. Гэтэл энэ байдал манай улсын хувьд тааруу гарсан байх нь. Ялангуяа Монголбанктай холбоотой арилжааны банкууд бус Санхүүгийн зохицуулах хорооны хяналтанд байгаа банк бус санхүүгийн салбарт асуудал гарсан байх нь?

Санхүү талаас нь аваад үзвэл ийм дүр зураг гарч ирж байгаа. Нөгөө талаас хууль сахиулах байгууллагын хувьд ямар байна вэ гэдэг асуудал. Энэ дээр олон

улсын байгууллагууд юуг хардаг вэ гэхээр мөнгө угаах гэмт хэргээр хэчнээн хүн шүүхээс ял авсан юм бэ, хэчнээн төгрөг хураагдсан бэ, энэ үйл ажиллагаандаа хууль сахиулах байгууллагууд гадаадын хууль сахиулах байгууллагуудтай хэрхэн хамтран ажилласан юм бэ гэдэг асуудлуудыг харж байгаа. Жишээ нь гадаадын нэг хүн манайд орж ирээд мөнгө угаах тохиолдол гарч болно шүү дээ. Манайх тэрийг нь илрүүлсэн тохиолдолд тухайн мөнгөний үндсэн эх сурвалж гарсан улстай холбоо бариад, тухайн мөнгийг буцааж өгсөн үү, үгүй юу. Эсвэл манай улсаас хэн нэгэн гэмт хэрэгтэн мөнгө угаагаад, тухайн улсад байршуулсан байлаа гэхэд мөнгөө буцааж авч чадсан юм уу гэх зэрэг асуудалд нэлээд доголдол гарсан.

Тэгэхээр энэ бас оффшортой холбоотой байх нь?

Мэдээж оффшортой холбоотой. Үүнд дотоодын хамтын ажиллагаанаас гадна гадаадын хамтын ажиллагаа үүнд чухал нөлөөтэй.

36-37 оффшор данстай төрийн албан хаагчид байна гээд нэг хэсэг л шуугисан. Тэр хүмүүсийн данстай холбоотой асуудлыг та бүхэн шалгадаг уу, эсвэл хууль хүчний байгууллагууд ажилладаг юм уу?

Хуулийн дагуу бид зөвхөн мэдээлэл дээр ажилладаг. Улмаар шаардлагатай бол хууль сахиулах байгууллагад илгээдэг. Тэгэхээр оффшортой холбоотой асуултуудын хариултыг хууль сахиулах байгууллагынхнаас авсан нь дээр байх.

Гэхдээ та бүхэнд Монгол

Шүүхийн байгууллагууд энэ төрлийн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар туршлага хомс, шийдвэрлэсэн хэрэг байхгүй гэсэн дүгнэлтүүд гарсан

Улсын банкаар орж ирж байгаа бүх мэдээллүүд харагдаж байгаа биз дээ?

Бүх мэдээлэл биш л дээ. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдүүд 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдэгдэх ёстой.

Америкт бол 10 мянган ам.доллар байдаг юм билээ. 10 мянган ам.доллар хүнд өгөх, авах болоход заавал мэдээлдэг?

Тийм. Манай хувьд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх ёстой. Харин валютын хувьд төгрөгөөр илэрхийлэгдэх дүн нь 20 сая

төгрөгөөс дээш байвал бэлэн болон бэлэн бус аль алийг нь мэдээлэх үүрэгтэй. Энэ бол зөвхөн мэдээллийн л процесс.

Иймэрхүү дүнтэй гүйлгээ, үйл ажиллагаа том компаниудад өдөр бүр л болж байгаа. Та бүхэн хэн нь, юу хийгээд байгааг яаж ялгах вэ?

Хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдүүд сэжигтэй гүйлгээний тайланг ирүүлэх эрхтэй. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр бид түрүүн ярьсанчлан гэнэт их хэмжээний мөнгөн гүйлгээ хийсэн ч юм уу. Эсвэл тухайн харилцагчаас асуухад тайлбарлаж чадаагүй гэх зэрэг тохиолдолд тайлан ирүүлдэг гэсэн үг.

Тэгвэл банкны хувьд харилцагчийнхаа дансны үлдэгдэл, хэлбэлзэл зэргийг ерөнхийд нь ажиглаж байгаа. Тэрнээсээ хэт том мөнгөн дүнгийн талаар гэнэт яриад эхэлбэл, анхаарал татах нь байна. Түүнээс биш энэ хүн энэ хэмжээний мөнгө эргэлдүүлэх боломжтой гэдэг нь харагдаж байвал, асуудал биш.

Тийм. 20 саяас дээш үнийн дүнтэй гүйлгээний мэдээллүүд манай дээр статистик болоод л явах юм.

Танай тайлан дээр 2017 онд сэжигтэй гэж үзсэн 15, 2018 онд 181 гүйлгээний мэдээллийг цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх байгууллага болон гадаад улсын ижил төстэй байгууллагаар шалгуулахаар шилжүүлсэн гэж дурдсан байна. Ерөнхийдөө ямар тохиолдолд та бүхэн сэжигтэй гэж үзээд, хууль хяналтын байгууллагад шилжүүлээд байна вэ?

Хувь хүн, байгууллагад

хамаарсан дэргэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй. Ерөнхий дүр зураг нь юу вэ гэхээр гэнэт их мөнгө орж ирсэн, эсвэл иргэн хүн тайлбарлаж чадаагүй тохиолдлууд байна. Өөр нэг жишээ гэвэл дансанд нь гэнэт их хэмжээний мөнгө орж ирээд, тэр өдөртөө буцаад гарсан байдаг. Сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэхэд үүн дээр мөнгөн дүн болон бэлэн, бэлэн бус гүйлгээ эсэх асуудал хамаагүй байдаг.

Мөнгө угаах гэдэг нь хууль бусаар олсон мөнгийг банкаар дамжуулахыг л хэлээд байгаа шүү дээ.

Банкаар байж болно. Өөр сувгаар ч байж болно. 2018 оны дөрөвдүгээр сарын 18-нд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт орсон. Хуулийн дагуу бид үнэт металл, үнэт чулуугаар хийсэн бүтээгдэхүүнийг арилжаалдаг бизнесүүдийг мэдээлэх үүрэгтэй этгээд байхаар тусгаж өгсөн. Өндөр үнэтэй чулуу, үнэт эдлэл зарим тохиолдолд төлбөрийн хэрэгсэл болдог. Өмнө нь бид энэ чиглэлийн бизнесийг анхаарлын гадна үлдээсэн байсан. Энэ нь ч 2017 оны тайлан тааруу үнэлгээтэй гарахад нөлөөлсөн.

Үнэт металл гэхээр жишээ нь алт байна. Алтны татвар 2.5 хувь байж байгаад эргээд өсөнгүүт алт тушаалт буурчихаад байгаа. Монголбанк өнгөрсөн жил анх удаа 22 тонн алт худалдан авсан. Гэтэл Монголд байгаа алтны нөөц, алтны компаниудын үйл ажиллагаа гээд харахаар 22 тонноос хангалттай их давахаар байдаг шүү дээ. Ялангуяа алтны татвар өндөр байх үед Монголбанкнд ердөө 2.5 тонн

алт тушаагдаж байсан түүх ч байдаг. Энэ зөрүү нь хилээр маш их хэмжээгээр хууль бусаар гарсан гэж үздэг. Энэ асуудлын талаар та бүхэнд мэдээлэл байдаг уу. Үүнийг хэн, хаана шалгах ёстой юм бол?

Энэ чиглэлийн мэдээлэл бидэнд байхгүй. Яагаад гэвэл мэдээлэх үүрэгтэй этгээдүүд бидэнд зөвхөн санхүүгийнхээ мэдээллийг ирүүлдэг. Таны сая ярьсан жишээ өндөр татварыг дагаад далд эдийн засаг руу л орчихоод байгаа юм. Тэгэхээр хууль сахиулах байгууллагатай л илүү холбогдох байх.

2017 оны эцсийн дүнгээр гадаад улсуудад Монголын 147 мянган иргэн ажиллаж, амьдарч байна. Хүн амын 6 хувь. Эдний гадаадаас шилжүүлж байгаа мөнгө Дэлхийн банкны тайлангаар 2018 онд жишээ нь 320 орчим сая ам.доллар байна. Өдөрт бараг нэг сая доллар шилжүүлээд байгаа юм. Энэ урсгал гацаад байна шүү дээ. Үүнийг хэзээ болиулах юм бэ? Үүний тулд яах ёстой юм бол. Миний ойлгосноор манай улс саарал жагсаалтад орчихсон, энэ оны есдүгээр сар хүртэл хараад, дахиж шалгаад болохгүй бол хар жагсаалтад оруулна гээд бид бүр их хэцүү байдалд орох юм шиг байна. Энэ талаар тайлбарлана уу?

Жагсаалтын хувьд бид эрчимтэй хяналтанд орсон байгаа. Эрчимтэй хяналтын хугацаа энэ оны зургаадугаар сард дуусна. ФАТФ-ын зургаадугаар сарын хурлаар асуудлыг хэлэлцээд, эцсийн шийдвэр нь 10 дугаар сард гарна. Яагаад эцсийн шийдвэр хойшлогдож гардаг вэ гэхээр энэ

нь Ази, Номхон далайн бүсийн бүлгийн хурал ФАТФ-ын 6 болон 10 дугаар сард болдог хоёр хурлын дундуур болдог. Бид ФАТФ биш Ази, Номхон далайн бүсийн бүлгийн гишүүн учраас өөрийнхөө бүлгийн хурал дээр тайлангаа тавьдаг. Иймээс манай бүлгийн хурлаас гарсан шийдвэр ФАТФ-ын 10 дугаар сард болох хуралд л очно гэсэн үг.

Тэгсэн мөртлөө ФАТФ биднийг эрчимтэй хяналтанд оруулчихаад байгаа?

Тийм. Яагаад гэвэл бүс нутгийн бүлгийн байгууллагууд угаасаа л ФАТФ-ын 40 зөвлөмжийг тухайн бүсийн улсууддаа хэрэгжүүлэх үүрэгтэй шүү дээ. Тухайн бүсийн бүлгийн улсууд ФАТФ-ын зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар ФАТФ-д тайлагнадаг. Тийм учраас болохгүй байгаа орнуудыг ФАТФ өөрийн хяналтандаа татаж авдаг. Эрчимтэй хяналтанд орсон гэдэг чинь бид "саарал" жагсаалтад нэг хөлөөрөө орчихсон байгаа гэсэн үг. Хэрвээ 10 дугаар сард асуудал муугаар эргэвэл бид "хар" биш "саарал" жагсаалтад орно. Үүнээс зайлсхийх зорилгоор ямар арга хэмжээ авсан бэ гэхээр 2017 оны 12 дугаар сард Засгийн газраар ажлын төлөвлөгөө батлуулаад, СМА-ны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтаар төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан. Хийсэн ажлын үр дүн сайн гарна гэж найдаж байна. 2019 оны нэгдүгээр сарын сүүлээр бид Ази, Номхон далайн бүсийн бүлэгд Харилцан үнэлгээний тайлан гарснаас хойш хоёр дахь тайлангаа явуулсан. Энэ тайлангаараа зарим муу дүнгээ сайжруулах захиалгаа өгсөн. Ажлаа

хэр зэрэг сайн хийсэн бэ гэдгээ бид наймдугаар сард мэдэх болно.

Та банкны салбар харьцангуй гайгүй, банк бус санхүүгийн байгууллага дээр асуудал байна гэж хэлсэн. Санхүүгийн зохицуулах хороо хянадаг. Тэр хороо банк бус санхүүгийн салбараа хэр хянаж байна вэ, ямар ахиц гарсан бэ?

Санхүүгийн зохицуулах хороо өөрийнхөө зохицуулалтад байгаа салбарууддаа тус бүр эрсдэлийн үнэлгээ хийсэн. Түүнтэй холбогдуулаад, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог бий болгох анхны алхмаа хийж байгаа. Үүн дээр бас нэг асуудал байгаа нь хүний нөөц. Санхүүгийн салбар болон хууль сахиулах байгууллагын аль алинд нь байна. Санхүүгийн зохицуулах хороо эрсдэлийн үнэлгээнүүдээ хийсэн, хүмүүсээ томилсон, олон улсын зарим байгууллагуудаас сургалтуудаа авсан байна. Мөн банк бус, даатгал, үнэт цаасны салбарын компани, аж ахуйн нэгжүүдийг сургалтад хамруулаад эхэлчихсэн байгаа. Өөрөөр хэлбэл, алхмууд хийгдэж байгаа.

Мэдээж тодорхой алхмууд хийгдэж байгаа. Гэхдээ 10 дугаар сард шийдвэр гарахдаа саарал жагсаалт руу ч орж мэднэ. Эсвэл хар жагсаалт руу ч орж магадгүй юм уу?

Зөвхөн "саарал" жагсаалтын тухай яригдаж байгаа.

Эрчимтэй хяналтанд орсон, тэрнээс гарах, "саарал" жагсаалт руу орохгүй байхын тулд тодорхой ажлууд хийгдэж байна. Тэгэхээр бусад улс оронтой харьцуулахад манай улс энэ

хүнд нөхцөл байдлаасаа хэр хурдтай гарч байгаа вэ?



Бусад улс оронтой харьцуулахад бид ижил түвшинтэй байгаа. Адилхан асуудалтай орнуудын хувьд шүү дээ. Жишээ нь Шри-Ланка байна. Мөн Камбож улс байна. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулиа өөрчилж, зарим тохиолдолд бүр шинэчилсэн найруулга хийж байна. Бид бас яг энэ замаараа л явж байгаа.

Сүүлийн асуулт. Япон жишээ нь хадгаламжийн хүү бараг хасах хувьтай болчихсон. Мөнгө хадгалвал торгуулихаар хэмжээнд хүрчихсэн. Тэгэхээр тэнд байгаа илүүдэл мөнгөө Монголд авчраад, банк бус санхүүгийн байгууллагад хадгалуулаад, өсгөөд, буцаагаад явуулахад болно биз дээ. Монгол Улс мөнгөний чөлөөт урсгалтай орон шүү дээ?

Үүнд мэдээж асуудал байхгүй. Гол нь тэр мөнгөө цэвэр гэдгийг л нотлох ёстой.

Маш чухал асуудлаар ярилцлаа. Танд баярлалаа.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 28/III ӨДРИЙН БАЙДЛААР)**



ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫН АСУУДЛУУД

Эдийн засаг, санхүүгийн салбаруудад тодорхой бус байдлыг эрсдэл хэмээн тооцож, хүлээж авдаг. Тэгвэл олон улсын эдийн засагт тодорхой бус байдлыг бий болгож байгаа томоохон хүчин зүйлсийн талаар Монголбанкны мэдээлэл товхимлын энэ удаагийн дугаартаа онцолж байна. Уншигч эрхмийн бодож байгаагчлан дэлхийн өнөөгийн эдийн засагт үүсээд байгаа хамгийн том гэж хэлж болох тодорхой бус байдлууд бол АНУ, БНХАУ хоёрын хооронд үүсээд байгаа худалдааны маргаан болон Их Британи Улс Европын холбооноос гарах “Брексит” юм.

Эдийн засгийн бодлогыг боловсруулж, тодорхойлоход ихэвчлэн байгаа мэдээллийг ашигладаг билээ. Үүнд өнгөрсөн болон одоо байгаа түүхэн мэдээлэл, түүний цаашдын хандлага түүнчлэн цаашид болохоор тодорхой болсон мэдээллүүд багтана. Эдгээр бүх мэдээллийг үндэслэн хэд хэдэн загварчлалыг ашиглан ирээдүйн бодлогын эх суурийг бий болгодог. Бодлого ирээдүйд бодитой, үр ашигтай хэрэгжихэд тодорхойгүй байдал багагүй нөлөөтэй. Ялангуяа, дэлхийн нийт глобалчлагдсан энэ цаг үед олон улсын эдийн засагт нөлөөлөхүйц томоохон хүчин зүйлс нь бодлогод хамгийн их эрсдэлийг бий болгодог. Өөрөөр хэлбэл сурах бичиг дээр заасанчлан бусад хүчин зүйлс тогтмол буюу “ceteris paribus” нөхцөл хангагдахад ихээхэн хязгаарлагдмал бөгөөд зөвхөн тодорхой орчинд л биелэгдэх

боломжтой байдаг. Тиймээс тодорхой бус байдал нь бодлогын баримт бичгийн нэг чухал хэсэг болж дурдагддаг байна.

Худалдааны маргаан

2018 онд дэлхийн эдийн засагт урган гарсан нэг томоохон үйл явдал бол АНУ болон БНХАУ-ын хоорондох худалдааны маргаан юм. Үйл явдлын эхлэл нь, БНХАУ анх 2001 онд Дэлхийн худалдааны байгууллагад элсэх үед тавигдсан бөгөөд АНУ-ын үе үеийн удирдлагууд шийдэж чадахгүй байсаар өнөөгийн нөхцөл байдалд хүрчээ. Нэг талаас АНУ-ын одоогийн Ерөнхийлөгчийн “Америк Улсыг дахин хүчирхэг болгох” уриатай сонгуульт ажлын биелэл болж 2018 оны 1-р сард Доналд Трамп БНХАУ-ыг худалдаанд тэгш бус оролцож байгааг эсэргүүцэн тариф тавьсан. АНУ-ын зүгээс хоёр улсын худалдаанаас жил бүр 225-600 тэрбум орчим ам.долларын алдагдал хүлээж байгааг онцолж, БНХАУ-ыг оюуны өмчийг хүндлэхгүй байгаа байдлыг эсэргүүцэн 1300 төрлийн бараанд тариф тавихаа зарласан. Нөгөө талаас БНХАУ үүнийг эсэргүүцэж, АНУ-аас орж ирдэг 128 төрлийн бараанд тариф тавиад байгаа билээ. Асуудал хурцадмал байдалд орж, 2018 оны 11 сар гэхэд АНУ нь БНХАУ-ын 200 орчим тэрбум ам.долларын бараанд тариф тавьж байгааг зарласан бол БНХАУ нь АНУ-ын 110 тэрбум ам.долларын бараанд тариф ногдуулахыг зар лалаа. 2018 оны 12-р сард энэхүү хурцадмал байдлыг түр намжаах

мэдэгдэл гарч, талууд 3 сарын хугацаанд хэлэлцээрийн ширээнд суухаар шийдвэрлэв.

Хэрвээ энэ хэлэлцээрээс дэлхийн эдийн засгийг хөдөлгөгч эдгээр том гүрний худалдааны маргаанд нөхцөл байдал нааштай эргэвэл Монгол Улсад ашигтай байх болно. Худалдааны маргаан идэвхжих үед БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч эхэлсэн бөгөөд үүнээс улбаатайгаар Монгол Улсаас худалдаж авах түүхий эдийн эрэлт буурах юм. Энэ нь цаашлаад эдийн засгийн бусад салбарт ч халгаатай тул хэрхэвч хүсэх зүйл биш. Тухайлбал, 2018 онд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 6.6 хувьд хүрсэн нь 1990 оноос хойших хамгийн тааруу үзүүлэлт бөгөөд 2019 оны хувьд эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 6.5-аас бууруулж 6.0-6.5 хувийн хооронд хэмээн тодорхойлсон байна. БНХАУ-ын нүүрсний зах зээл нэлээд хуваагдмал бөгөөд Монгол Улс хойд бүсэд түүхий эдээ нийлүүлдэг. Манайд дэд бүтэц төдийлөн хөгжөөгүй учраас зөвхөн энэ хязгаарлагдмал нөхцөл байдалд захирагдахаас өөр аргагүй. Тиймээс БНХАУ-ын хойд бүсэд үйлдвэрлэл буурах аваас нүүрс мөн зарим талаар бусад түүхий эдийн эрэлт буурч Монгол Улсад халгаатай юм.

АНУ-ын Холбооны Нөөцийн Банкны 3-р сарын бодлогын мэдэгдлээр бодлогын хүүг 2.5 хувьд хэвээр үлдээх шийдвэр гаргасан бөгөөд улмаар энэ жил дахин өсгөхгүй гэдгийг мэдэгдлээ. Холбооны нөөцийн банк 2018 онд бодлогын хүүг 4 удаа өсгөсөн бол 2019 онд

2 удаа өсгөх хүлээлтийг үүсгээд байсан ч худалдааны маргаан болон бусад тодорхой бус байдлаас үүдэн энэхүү шийдвэрийг гаргажээ. 2018 оны 3-р сар гэхэд худалдааны хэлэлцээр ямар нэг үр дүнд хүрнэ хэмээн хүлээж байсан ч өдгөө эцсийн хэлэлцээрт хүрээгүй байна. Талууд хэлэлцээрийн ширээнд эерэг хандлага ноёлж байгааг онцолж байгаа ч оюуны өмчийн маргаан, мэдээлэл холбооны асуудлууд шийдэгдээгүй байсаар байна. АНУ-ын хувьд дан ганц БНХАУ гэлтгүй Канад, Мексик зэрэг олон оронтой худалдааны маргааны өрнүүлээд байгаа. Энэхүү тодорхой бус байдал нь дэлхийн эдийн засгийн сэргэлтэд тушаа болж байгааг нэг бус судлаач анхааруулж байгаа. Ерөнхийлөгч Трамп 2020 онд дахин сонгогдохын тулд худалдааны асуудлуудыг шийдвэрлэх нь нэн тэргүүний асуудал юм. Учир нь худалдааны протекционист бодлого нь аль ч талд ашиггүй аж.

Брекситийн уналт

Энэ сард эцэслэхээр хүлээгдэж байсан өөр нэг үйл явдал бол Брексит буюу Их Британийн Нэгдсэн Вант Улс нь Европын холбооноос гарах байсан юм. Анх 2016 онд иргэдийн дунд албан ёсны санал асуулга явуулахад 51.89%-ийн саналтайгаар гарахыг дэмжсэний үр дүнд хоёр тал 2019 оны 3-р сарын 29-ний өдрийг “чухал” өдөр болгон зарласан. Санал асуулгын үр дүнг сонирхуулахад Умард Ирланд болон Шотландын бүс нутгийн иргэдийн дийлэнх нь үлдэхийг дэмжсэн бол Англи болон Уэльсийн бүс нутагт гарах санал өгсөн аж.

Их Британи Европын холбоонд анх 1973 онд нэгдэхээр болж 1975 онд бүх нийтийн санал асуулгаар

баталгаажсан байдаг. Хэдийгээр мөнгөнтэмдэгтээ еврод хөрвүүлэлгүй фунт стерлингээ хадгалж үлдсэн ч гэлээ санхүү, худалдаа зэрэг нийгэм-эдийн засгийн бүхий л түвшинд интеграцчилагдаж, нэгдмэл болсон байна. Өдгөө хоёр тал хэрхэн салах тал дээр томоохон хэлэлцээрүүдийг хийсэн ч, Английн парламент Брюссельтэй байгуулах гэрээний төслийг хэд хэдэн удаа дэмжихгүй, буцааснаар хугацааг 5-р сарын 22 хүртэл сунгахад хүрлээ. Европын холбооны гишүүн 27 орны төр засгийн тэргүүн нар, Брекситийн тухай 585 хуудас бүхий гэрээг дэмжсэн бөгөөд хоорондын харилцааг зохицуулах тунхагийг бий болгосон ч Лондон хотноо Парламентийн тэнхимд дэмжигдэж байж хэрэгжих юм. Үүнд худалдаа, нийгэм-эдийн засгийн хэлэлцээрүүд багтаж байгаа ба хамгийн гол нь тарифын асуудал мөн сөхөгдөж байгаа. Гэрээнд Их Британийн ашиг сонирхлыг бүрэн хамгаалагдахгүй байна гэдэг үндэслэлээр Английн парламент дээр удаа дараа унаж Тереза Мэй болон түүний засгийн газрыг хүнд байдалд оруулав.

Хэрэв энэ асуудлыг Монголын эдийн засгаас хол хөндий гэж үзвэл үнэхээр эндүүрч байгаа хэрэг болно. Хэдийгээр манай улсын эдийн засаг хоёр хөрш, тэр дундаа БНХАУ-ын худалдан авах эрэлтээс ихээхэн хамаарч байгаа ч гэлээ, дэлхий глобалчлагдсан энэ үед тэнд үлээж байгаа салхи энд шуурга болох аюултай. PwC болон Schrodgers байгууллагуудын тайлан ч хөгжиж байгаа орнуудад Брексит эрсдэл бий болгож байгааг анхааруулсан. Тухайлбал, хэрэв Брексит хэлэлцээрт

хүрч чадахгүй эсвэл хатуу нөхцөлтэйгээр эцэслэвэл Английн худалдааны тариф чангарч Монгол Улстай ижил өрсөлдөх чадвар бүхий улс орнууд нэвтрэхэд хүндрэл үүснэ. Энэ үед тэдгээр улсууд бусад худалдан авагчдыг хайх ба БНХАУ тэргүүн эгнээнд багтах тул Монголын экспортод халгаатай. Нөгөөтэйгүүр Монгол Улсын гол экспортын бүтээгдэхүүн – ноолуурыг худалдаж авдаг томоохон түнш бол Их Британи. Хэрэв тариф тавигдаж эхэлбэл н оолууран бүтээгдэхүүний экспорт буурах аюултай. Улмаар валютын гарах урсгал тогтмол нэмэгдэж байх үед орох урсгал татарвал валютын ханшид дарамт үзүүлж эргүүлээд инфляци, эдийн засгийн эрсдэлийг үүсгэж болно. Монгол Улс 2018 оны эцсийн байдлаар нийт 173 орчим сая ам.долларын экспортыг Их Британи руу хийсэн байгаа ба энэ нь мөн үед ОХУ-д экспортолсон хэмжээнээс ч их байгаа юм.

Дэлхийн эдийн засагт 2008 оны санхүүгийн хямрал нүүрлэснээс хойш иргэд, олон нийт эдийн засаг, санхүүгийн салбарт итгэх итгэл сулраад байгааг Дэлхийн эдийн засгийн форумын үеэр онцолсон. Улмаар протекционист буюу глобалчлалын эсрэг хандлагыг бий болгож, улс орнуудын хамтын ажиллагаа сулрахад хүргэж байгаа. Энэ нь ч эргээд популизмыг тэтгэж байгаа учраас 2019 оны Дэлхийн эдийн засгийн форумоос глобалчлал 4.0 буюу улс орнууд бие даасан байдлаа хадгалах замаар хамтын ажиллагааг хангах санаачлагыг гаргасан. Энэ бүх тодорхойгүй байдал үргэлжлэх аваас Монгол Улсын эдийн засагт ч эрсдэлийг бий болгох талтай.

Эх сурвалж: <https://www.bbc.com/news/uk-politics-47660019>
<https://www.pwc.nl/en/eu-referendum/brexit-monitor/the-impact-of-brexit-on-emerging-markets.html>
<https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2018/12.pdf>



ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮЛЭЭЛТИЙН ИНДЕКС (CONSUMER SENTIMENT INDEX (CSI)-ИЙН СУДАЛГАА

Монголбанкнаас улирал бүр эрхлэн гаргадаг "МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" сэтгүүлийн 10 дахь дугаараас онцлов.

Г.НАРАНГОО¹, Г.ГАНЗОРИГ²

Эдийн засагт үйлдвэрлэгч, хэрэглэгч, Засгийн газар, Төв банк гэсэн үндсэн дөрвөн оролцогч байдаг. Эдийн засгийн онолд эдгээр оролцогч нь өөрийн үндсэн зорилго, хүлээлтэд тулгуурлан шийдвэр гаргадаг гэж үздэг. Эдийн засгийн оролцогчдын зорилго тогтвортой байдаг бол хүлээлт нь цаг хугацааны туршид өөрчлөгдөж байдаг учраас эдийн засагт оролцогчдын хүлээлтийг тодорхойлох нь эдийн засгийг таамаглахад чухал ач холбогдолтой юм. Тэгвэл шийдвэр гаргалтын үндсэн хүчин зүйл болох хүлээлтийг тодорхойлох нь хэрэглэгчийн хүлээлтийн индексийн үндсэн зорилго юм.

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (ХХИ) өсөх нь эдийн засаг өсч, өрхийн орлого нэмэгдэж байгааг харуулах бөгөөд хэрэглэгчид хэрэглээгээ нэмэгдүүлэх, цаашлаад хадгаламж, хөрөнгө оруулах шийдвэрт хүргэдэг. Харин ХХИ буурах нь иргэдийн худалдан авалт буюу эдийн засаг дахь эрэлт буурах, идэвхжил сулрах үр дүн бий болохыг илэрхийлдэг ажээ.

1. Судалгааны аргачлал, үзүүлэлт

Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн судалгааны эх олонлог нь ажил эрхлэгчид бөгөөд Монгол Улсад 2018 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 1,238.9 мянган хүн ажил эрхэлж байна. Эдийн засгийн 14 салбарын нийт 901 ажил эрхлэгчийг түүвэрлэн, биечлэн ярилцах замаар хийсэн. эх олонлогийг төлөөлөх түүврийн хэмжээний чадвар нь 99 хувь байна.

Хүснэгт 1. Судалгааны түүвэрлэлтийн үзүүлэлт

№	Салбар	Түүврийн хэмжээ
1.	Барилга	69
2.	Боловсрол	73
3.	Боловсруулах (хүнсний үйлдвэрлэл, ундаа, хувцас, хэрэглээний бүтээгдэхүүнүүд, эм гэх мэт)	65
4.	Бөөний болон жижиглэн худалдаа	77
5.	Зочид буудал, зоогийн газар	39
6.	Мэдээлэл холбоо	72
7.	Санхүү, даатгалын үйл ажиллагаа	70
8.	Төр, батлан хамгаалах	70
9.	Тээвэр, агуулах	59
10.	Уул уурхай, олборлолт	69
11.	Үйлчилгээ	68
12.	Үл хөдлөх хөрөнгө	30
13.	Хөдөө аж ахуй, загас, ойн аж ахуй, ан агнуур	71
14.	Эрүүл мэнд	69
Нийт		901

2. Судалгааны үр дүн

2.1. Эдийн засгийн хүлээлт

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс өмнөх улирлаас 16 нэгжээр буурлаа.


Хэрэглэгчийн хүлээлтийн индекс 2018 оны дөрөвдүгээр улиралд өмнөх улирлаас 16 нэгжээр буурч 156-д хүрлээ. Хүлээлт ийнхүү буурахад Улсын Их

¹ Голомт банкны эдийн засгийн шинжээч. Цахим шуудан: narangoo@golomtbank.com, утас: 88132325

² Голомт банкны эдийн засгийн ахлах шинжээч. Цахим шуудан: Ganzorig_gan@golomtbank.com, утас: 91977333

Хурлын тогтворгүй байдлаас гадна мах, бензин, хатуу түлшний үнийн өсөлт, ханшийн өсөлт зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна. Индексийн бүтцийг харвал сүүлийн нэг жилд гэр бүлийнхээ санхүүгийн байдлыг сайжирсан гэж үзэж байгаа хэрэглэгчийн хувь тогтмол өсөж байгаа бол дөрөвдүгээр улиралд өнөөдрийн эдийн засгаа сайн гэж үнэлсэн хэрэглэгчдийн тоо 3.7 нэгж хувиар бууржээ.

Зураг 1 Хүлээлтийн индекс



2.2. Хадгалах хандлага ба санхүүгийн зах зээл


Хэрэглэгчийн хүлээлт нь иргэдийн хэрэглээ болон хадгаламж дээр тусгалаа олдгийн учир нь хэрэглэгч өөрт байгаа мэдээлэлдээ тулгуурлан үндсэн хоёр шийдвэр гаргадаг нь хадгалах болон хэрэглэх юм. Хэрэглэгчийн хэрэглэх хандлага өндөр байна уу, эсвэл хадгалах хандлага өндөр байна уу? гэдгээс шалтгаалан хэрэглэгчийн хүлээлтийн эдийн засагт үзүүлэх нөлөө нь өөр өөр байдаг. Хэрэв иргэд хэрэглээгээ илүү нэмэгдүүлвэл эдийн засаг хэрэглээгээр дамжин өсөх бөгөөд энэ нь эрэлтэд суурилсан инфляцийг өдөөдөг. Харин хадгаламж илүү бол банкны зээл олгох боломж нэмэгдсэнээр эдийн засагт нөлөөлнө.

Хэрэглэгчийн орлого 30 хувиар нэмэгдвэл 53 хувь нь хэрэглээнээс илүү хуримтлалаа нэмэгдүүлнэ гэж хариулж байсан бол дөрөвдүгээр улиралд 45 хувь болж буурчээ. Харин хэрэглээ болон хадгаламжаа тэнцүү нэмэгдүүлэх хэрэглэгчдийн хувь 26-39 хувь болж өссөн байна. Харин хэрэглээг илүүд үзэж буй хэрэглэгчдийн эзлэх хувь хэмжээ 10 хувь байна.

Ам.долларын ханшийн хүлээлтэд огцом өөрчлөлт гараагүй.

Өмнөх улиралтай харьцуулахад ам.долларын ханшийн өсөх болон буурах хүлээлт аль аль нь буурч тогтвортой байх хүлээлт гурван нэгж хувиар өссөн байна. Тодруулбал хэрэглэгчдийн 53 хувь нь өснө, 10 хувь нь буурна, 37 хувь нь тогтвортой байна гэсэн хүлээлттэй байна.

Зураг 2. Ирэх нэг жилийн хугацаанд ам.долларын ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?



Ам.долларын ханшийн өсөлт 2016 онд 25 хувьд хүрч байсан бол 2017 онд -2.5 хувиар буурч, 2018 онд 8.9 хувиар өссөн байна. Олон улсын байгууллага болон эдийн засагчдын таамаглалаар 2019 онд эдийн засгийн өсөлт 6-8 хувьтай байхаар хүлээгдэж байна. Мөн хэрэглэгчдийн хүлээлтийн индекс ам.долларын ханшийн хувьд харьцангуй тогтвортой байгаа нь ам.долларын ханшийн өсөлтийн хувь 2018 оны түвшинд байх таамаглалыг өгч байна.

2.3. Хэрэглэх хандлага ба худалдан авалт

Эдийн засгийн нөхцөл байдал сайн байгаа үед хэрэглэгчдийн худалдан авалт дагаад өсдөг. Худалдан авалтын өөрчлөлт нь удаан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүний эрэлтэд түлхүү суурилна гэж үзэн машин, орон байр, аялал, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл гэсэн дөрвөн төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон авч судалгаанд хамрууллаа.

3. Дүгнэлт


Хэрэглээний хүлээлт 2018 оны дөрөвдүгээр улиралд өмнөх улирлаас буурсан байна. Эдийн засгийн өсөлт тогтвортой байгаа үед хүлээлтийн индекс огцом унасан нь улс төрийн тогтворгүй байдалтай шууд холбогдож байна. Дөрөвдүгээр улиралд Засгийн газрыг огцруулах асуудлыг УИХ-аар хэлэлцэж, УИХ-ын даргыг огцруулах талаар яригдан, жагсаал цуглаан зохион байгуулж байгаа нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа мэтээр иргэдэд мессеж өгсөн. Мөн дөрөвдүгээр улиралд эдийн засгийн голлох үзүүлэлт сайн гарсан ч зарим сөрөг үзүүлэлтийг дурдах нь зүйтэй. Эдгээрт инфляцийн өсөлт, тэр дундаа мах, бензин, хатуу түлшний үнийн өсөлт, мөн төгрөгийн ханшийн сулрал зэрэг юм.

Ам.долларын ханшийн хувьд хүлээлтийн индексэд огцом өөрчлөлт гараагүй нь хүлээлтээр дамжсан ам.долларын эрэлт үүсэх, ханшийг савлуулах нөлөө гарахгүй гэсэн таамаглалд хүргэж байна.


Төв банк 2018 оны арваннэгдүгээр сард бодлогын хүүг нэг нэгж хувиар өсгөн 11 хувьд хүргэсэн нь зээлийн хүү өсөх хүлээлт давамгайлахад нөлөөлжээ гэж үзэж байна. Харин инфляцийн түвшинг ирэх 12 сард тогтвортой байхаар хүлээж байгаа нь сүүлийн хоёр жилд инфляцийн түвшин харьцангуй тогтвортой буюу 8 хувь (төв банкны зорилтот түвшин) орчимд байсантай холбоотой.

Иргэдийн хадгалах хандлагын хувьд бага зэрэг буурсан байгаа нь өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлын хүлээлт буурсантай холбоотой. Мөн хэрэглэх хандлага ч энэ улиралд бууралттай гарсан байна. 2018 онд хэрэглээний импорт 28 хувь өссөн, төв банкнаас хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого хэрэгжүүлж байгаа нь ирэх нэг жилийн хэрэглээний өсөлтийг сааруулах нөлөө үзүүлнэ.

Зураг 3. Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн бүтэц
Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (насны бүлгээр)



Зураг 4. Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (хүйсээр)




ИПОТЕК

Монголбанк орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд сард дунджаар тус хөтөлбөрийн эргэн төлөлтөөр 16 орчим тэр бум төгрөгийн санхүүжилтийг тогтмол хийдэг билээ. 2019 оны 3 дугаар сарын хувьд 15.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 197 иргэнд огосон бөгөөд оны эхнээс өссөн дүнгээр нийт 47.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 684 иргэнд олгоод байна.


Харин 2018 онд нийт 309.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 4,676 иргэнд олгосон бөгөөд үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 191.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2,768 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 118.1 тэрбум төгрөгийг 1,908 иргэнд олгосон юм.

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл




Тайлант сард банкууд 337 зээлдэгчид 22.5 тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 27.5% нь ОССТБ хөтөлбөрийн, 72.5% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү



Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сар болон өмнөх оны мөн үетэй ижил түвшинд буюу 12.5% байна.


Зураг 3.3. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



- Ипотекийн нийт зээлийн үлдэгдлийн 74.8% нь хөтөлбөрийн зээл, 23.0% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.2% нь бусад эх үүсвэрээр олгосон зээл эзэлж байна.
- Орон нутгийн ипотекийн зээл-ийн 78.1% нь хөтөлбөрийн зээл, 21.1% нь өөрийн эх үүсвэрээр, 0.8 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

*3%-гээс ирэн нутгийн банкны салбараас олгосон бүс тухайн авсан орон сууцны байрлаар тооцсон.

Зураг 3.4. Нийт зээлдэгчдийн тоо болон жилийн өсөлт



БАНК ЯАГААД ХАРИЛЦАГЧАА БҮРЭН ТАНЬЖ МЭДЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙДАГ ВЭ?

Харилцагч таныг банкнаас үйлчилгээ авах үед таны мэдээлэл шинэчлэгдсэн эсхийг асууж байсан уу. Эсхүл салбар нэгж дээр биечлэн очиж мэдээллээ шинэчлэх шаардлагыг банкнаас тавьсан уу?

Энэ нь Банкны зүгээс харилцагчтай аливаа харилцаа тогтоож, үйлчилгээ үзүүлэхийн өмнө харилцагчаас тодорхой мэдээллийг гаргуулан авах, цаашид мэдээллийг тогтмол шинэчлэх байдлаар харилцагчаа бүрэн таньж мэдэх ажиллагаа хийх хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу тавьж буй шаардлага юм.

Банк яагаад харилцагчаа таньж мэдэх шаардлагатай байдаг вэ?

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу Банк нь харилцагчаа таньж мэдэх, мэдээллийг тогтмол шинэчлэх үүргийг хүлээдэг. Мөн түүнчлэн банк харилцагчийнхаа гадаад гүйлгээг түргэн шуурхай дамжуулах, үйлчилгээгээ олон улсын жишигт нийцүүлэн харилцагчдаа хүргэхийн тулд гадаадын банк санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллах, гадаадын дамжуулагч банкны үйлчилгээг авах хэрэгцээ шаардлага гардаг. Гэтэл гадаадын банк, санхүүгийн байгууллагаас тавьж буй хяналт чанга байхын сацуу, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон харилцагчаа таньж мэдэх ажиллагааны шаардлага нь маш өндөр байдаг. Ийнхүү харилцагчаа бүрэн таньж мэдсэн байх нь харилцагчид банкны үйлчилгээг саадгүй, түргэн шуурхай хүргэх боломжтой болох, улмаар харилцагч таныг санхүүгийн аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Харилцагч та ямар төрлийн мэдээллээ шинэчлэх шаардлагатай вэ?

Хэрэв та хувь хүн бол таны утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газар, албан тушаал гэх мэт, харин хуулийн этгээдийн хувьд хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, үйл ажиллагааны чиглэл зэрэг өмнө нь банкинд өгсөн аливаа мэдээлэлд өөрчлөлт орох бүрт мэдэгдэж, шинэчлэх шаардлагатай. Энэхүү мэдээлэлд үндэслэн харилцагчийн орлого, мөнгөн хөрөнгө нь хууль ёсны бөгөөд аливаа гэмт хэргийн улмаас олсон мөнгийг угаах аливаа эрмэлзэлгүй болохыг баталгаажуулах зорилготой юм.

Банкнаас шаардсан мэдээллийг харилцагч гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд яах вэ?

Банкнаас шаардсан мэдээллийг харилцагч гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд банк нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу танд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүргийг хүлээдэг. Нөгөө талаар харилцагч та банкинд бүрэн зөв мэдээллээ гаргаж өгөөгүй, мэдээллээ шинэчлээгүйн улмаас банкны шинэ үйлчилгээ, түүнтэй холбоотой хэрэгцээт мэдээллийг авахад хүндрэл учрах эрсдэлтэй.

Харилцагчийн мэдээллийг хэр давтамжтай шинэчлэх ёстой вэ?

Банк нь харилцагчийн мэдээлэлд өөрчлөлт орсон эсэхэд тогтмол хяналт тавих үүрэгтэй. Түүнчлэн дээр дурдсаны дагуу харилцагч нь мэдээллээ шинэчлэгдэх бүрт банкнаас тавих хяналтаас үл хамааран банкинд мэдэгдэх гэрээгээр хүлээсэн үүрэгтэй.

Банк харилцагчийн мэдээллийг хэрхэн хамгаалдаг вэ?

Банк харилцагчийн мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд гаргаж өгөх, задруулах, ашиглахгүй байх үүрэгтэй. Тиймээс таны банкинд гаргаж өгсөн мэдээлэл зөвхөн харилцагч таныг болон банкинг эрсдэлээс хамгаалах зориулалтын дагуу ашиглагдах юм.

Мэдээллээ хэрхэн шинэчлэх вэ?

Харилцагч та өөрийн үйлчлүүлдэг банкны мэдээлэл шинэчлэх боломжит сувгийг ашиглан мэдээллээ шинэчилнэ.

Мөнгө угаах гэж юу вэ?

Мөнгө угаах гэдэг нь гэмт хэргийн буюу илт хууль бус замаар олсон хөрөнгийг хууль ёсны болгож

харагдуулахын тулд эх үүсвэрийг нь нуун далдалсан, шилжүүлсэн, хувиргасан зэргийг хэлнэ.

Мөнгө угаах олон арга байдгийн нэг нь тухайн орлогыг банканд байршуулах, банкны төлбөрийн системийг ашиглан бусдад шилжүүлэх замаар орлогын жинхэнэ эх үүсвэрийг нуун далдлах, өөрчлөх явдал юм.

Мөнгө угаах гэмт хэргээс бид яагаад урьдчилан сэргийлэх ёстой вэ?

Мөнгө угаах нь хээл хахууль, авилгыг дэлгэрүүлэх, шударга өрсөлдөөнийг үгүй хийх, улсын төсөвт орох орлого буурах, татвараа шударгаар төлөгч иргэдийг хохироох зэрэг нийгэм, эдийн засагт олон сөрөг үр дагавартай тул бид бүх нийтээр анхаарлаа хандуулж энэ асуудалтай тэмцэх нь чухал юм. Мөнгө угаах үйл ажиллагааны хяналтгүй байдал нь банкны төдийгүй санхүүгийн системийг бүхэлд нь сүйтгэх үр дагавартай байдаг.


Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

Терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор аливаа хөрөнгийг цуглуулах, олж авах, дамжуулах ажиллагааг ойлгоно. Мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог бол терроризмыг хууль ёсны орлогоор ч санхүүжүүлэх боломжтой байдаг. Дэлхийн улс орнууд терроризмын эсрэг нийтээрээ нэгдэж энх тайван, шударга ёс, аюулгүй байдлын төлөө тэмцэж байгаа бөгөөд үүний нэг илрэл нь банк санхүүгийн салбарт тавих хяналтыг улам чангатгаж байгаа явдал юм.

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2019/03/29-ний хооронд 934,7 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1020 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.

График 1. 2000-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



ГУРАВДУГААР САРД ... КГ АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2019 оны 3 дугаар сард 91 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 714 кг алт худалдан авч байсанаас 623 кг дутуу буюу 87%-иар буурсан үзүүлэлттэй байна. Монголбанк 2019 оны 3 дугаар сард 448 кг цагаан мөнгө худалдан авлаа.

Үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтсээс 9 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбараас 6 кг алтыг худалдаж авснаар бүрдүүлэв.

Алт худалдан авалт өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа нь "Ашигт малтмалын тухай хууль"-д 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү болгосон хуулийн хугацаа 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дуусгавар болсонтой холбоотой юм.

2019 оны 3 дугаар сарын байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 110,109.38 төгрөг байлаа.

Энэ нь Лондонгийн үнэт металлын захын үнэ өндөр байгаатай холбоотой юм. 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Лондонгийн үнэт металлын захын алтны хаалтын ханш 1309.70\$ /1 трой унцы/ байна.

График 1. 2000-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



График 2. 2019 оны 3 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ



“Хүн нэг өмөө босоод л
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)




ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,
хадгалагч, зээл тооцоологч, ипотека, төсөвлөгч зэрэг
тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



 /Mongolbank.mn

 /Санхүүгийн боловсрол

 @mongolbank_mn

 www.mongolbank.mn

 /Mongolbankmn

 info@mongolbank.mn

 11 310081